



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# 2015

ЖИЛИЙН ТАЙЛАН

# ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх	7
Эрх зүйн шинэчлэл	13
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	16
Улс төрийн санхүүжилт	21
Төрийн ил тод хариуцлагатай байдал	26
Мэдээллийн эрх чөлөө	26
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	30
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	33
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	36
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	44
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба бизнесийн орчин	48
Төрийн өмчит компаниудын засаглал	51
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Тэгш хамруулах боловсрол	54
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоо	58
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	59
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	62
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД	68

# ТОВЧИЛСОН ҮГ

ББЗХ	Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ДЭЗФ	Дэлхийн эдийн засгийн форум
ЕТГ	Ерөнхийлөгчийн тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС-ХЗС	Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль
МУ	Монгол Улс
МҮОНРТВ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
ННФ	Нээлттэй нийгэм форум
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл эвсэл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УДЭТ	Улсын драмын эрдмийн театр
УЗ	Удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЗС	Хууль зүйн сургууль
ХЗТТ	Хууль зүйн туслалцааны төв
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХИ	Хэрэглэгчийн хүлээлтийн индекс
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

## ӨМНӨТГӨЛ

**М**анай улсын хувьд 2015 он хүний эрхийг баталгаажуулах, ардчиллын үнэт зүйлсийг үйл хэрэг болгох, сайн засаглалыг бэхжүүлэхэд чухал жил байлаа. Нийтийн сонсголын тухай, Хууль тогтоомжийн тухай хуулиуд болон Захиргааны ерөнхий хууль Улсын Их Хурлаар батлагдан хэрэгжиж эхэллээ. Эдгээр хууль нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүхий л түвшинд олон нийт болон эрх ашиг нь хөндөгдсөн талуудын оролцоог баталгаажууллаа. Тэрчлэн, Шилэн дансны хууль хэрэгжсэнээр төрийн дансны ил тод байдал эрс дээшиллээ. Нээлттэй Нийгэм Форум (ННФ) энэ бүхий л үйлсэд өөрийн хувь нэмэр оруулж ирсэндээ баяртай байна.

2015 онд бид төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, түүнд хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавх болон хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн оролцоог илүү үр нөлөөтэй болгох чиглэлд олон чухал ажил санаачлан хийж гүйцэтгэлээ. ННФ-ын хамтран ажилладаг “Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум” нь хүний эрхийг баталгаажуулахад НҮБ-ын хүний эрхийн механизмуудыг өргөн ашиглахын зэрэгцээ, хүний эрхийн тулгамдсан асуудлуудаар хамтарсан нөлөөлөл хийж хууль тогтоомжийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх, хүний эрхийн зөрчлийг арилгахад үр нөлөөтэй ажиллаж ирлээ. Урлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол олгох нэг хэлбэр болох Тавилттай уншлагыг орон нутгийн театруудад танилцуулж, тэдний тоглолтыг дэмжсэн нь цаашид орон нутгийн театруудын олон нийтэд хүний эрхийн боловсрол, мэдлэг олгох санаа, сэдлийг өдөөлөө.

Хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлийг дэмжсэн үйл ажиллагаа 2015 онд ч үргэлжилж Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан хэрэгжилтэд нь мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх цуврал сургалтыг нийслэл болон 21 аймгийн төлөөллийг хамруулан хийлээ. Мөн цагдаагийн албаны ажиллагаанд хяналт тавьж шинээр хэрэгжиж эхэлсэн Иргэний зөвлөл болон Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаанд мониторинг хийж үр дүнг нь нийтийн хүртээл болголоо. Түүнчлэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр боловсруулж буй зарим чухал хуулийн төслөөр хэлэлцүүлэг өрнүүлж иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нэгтгэн бодлого боловсруулагчдад хүргэж ирлээ.

Шүүхийн шинэтгэлийн багц хууль хэрэгжих явцад тулгарч буй эрх зүйн болон практикийн асуудлыг судлан шинжилж, тодорхой зөвлөмж боловсруулж, холбогдох талуудад хүргэлээ. Шүүгчийн хараат бус байдал, тэдний томилгоо, шүүхийн тогтолцоог өөрчлөхтэй холбоотой бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, сорилт зэрэг асуудал нь дээрх судалгааг хийсэн мэргэжлийн

судлаачдын анхаарлын төвд байлаа. Мөн шүүхийн захиргааны дунд шатны ажилтнуудын мэргэжлийг бэхжүүлэх чиглэлд тодорхой ажлууд хийгдэж цаашид үргэлжлүүлэхээр төлөвлөөд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 21 аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ), аймгийн төвийн сумд, нийслэл болон дүүргийн ЗДТГ-уудад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийж, хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хууль тогтоогчид болон олон нийтэд байнга хүргэж ирлээ. Мөн 2016 оны улсын нэгдсэн төсвийн төслийг хөндлөнгийн шинжээчдээр үнэлүүлж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд болон иргэний нийгмийн хүрээнд танилцуулж, цуврал хэлэлцүүлэг өрнүүлээ.

ННФ-ын сүүлийн 10 жилд санаачилж, дэмжиж ажилласан ОУИТБС-ын үйл ажиллагааны ололт амжилт, сорилтыг 2015 оны 11 дүгээр сард олон талын оролцоог хангасан Үндэсний чуулганаараа нэгтгэн дүгнэж ирэх 4 жилийн стратегийн үндсэн чиглэлээ тодорхойллоо. ННФ уг чуулганд орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжсэнээр 13 аймаг, 11 сумын төлөөлөгчид ирж орон нутагт тулгарч буй асуудлаа үндэсний хэмжээнд хэлэлцүүлээ. Тэрчлэн, олборлох үйлдвэрлэлийн салбарын гэрээний ил тод байдлыг хангах чухал нөхцөл бүрдлээ. Үүнд, төр, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид болон иргэний нийгмийн оролцоотой явагдсан олон талт хэлэлцүүлгийн үр дүнд талуудын ойлголт, байр суурь нэгдэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцын зэрэглэлийг хүчингүй болгох зөвшилцөлд хүрлээ.

Боловсрол, нийгмийн бодлогын хөтөлбөрийн хүрээнд оролцогч талуудыг чадавхжуулах, бодлогод нөлөөлөх чиглэлд тодорхой ажлууд хийгдлээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа мэргэжлийн төвшинд хүрч, гишүүдийн чадавх болон сүлжээний үйл ажиллагаа бэхэжлээ. Тусгай сургуулийн багш нар эдгээр төрийн бус байгууллагатай хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах, нийтлэл бичих, анализ хийх зэргээр хамтын ажиллагааны санаачилгууд үүсэн бий болж байна. Түүнчлэн залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллах хамт олон, байгууллагууд бий болж байна. Энэ чиглэлээр ажилладаг их дээд сургуулийн мэргэжлийн баг, нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах эхлэл суурь ч бүрдэж байна.

Ийнхүү багцлан нэгтгэж, товчлон дүгнэж Та бүхний гарт хүргэж буй энэхүү тайланг уншиж танилцаад санал бодлоо хуваалцах аваас бид туйлын баяртай хүлээн авах болно. Түүнчлэн тодорхой үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.forum.mn](http://www.forum.mn) сайт руу орж үзнэ үү.

Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал



# ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

- ХҮНИЙ ЭРХ
- ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ
- ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ
- УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ
- ТӨРИЙН ИЛ ТОД ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

## ХҮНИЙ ЭРХ

**М**онгол Улс 2015 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон нь манай улсын хувьд хүний эрхийн салбарт гарсан онцгой тэмдэглүүштэй үйл явдал байлаа. Энэ үйл явцад Монголын хүний эрхийн ТББ-уудын Форум идэвхтэй оролцож Монгол Улс гишүүнээр сонгогдоход авч буй үүрэг амлалтад чухал, тодорхой саналуудыг орууллаа. Үүний дүнд ялгаварлан гадуурхалттай тэмцэх, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, хүрээлэн буй орчны асуудал, иргэдийн оролцоо, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх эрхийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрх зүйн шинэчлэлээ гүнзгийрүүлэх, Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх зүйн орчныг Хараат бус, бие даасан Хүний эрхийн үндэсний байгууллагын тухай Парисын зарчимд бүрэн нийцүүлэх зэрэг саналууд тусгагдсан юм. Түүнчлэн ННФ энэ онд өмнө нь эхлүүлсэн уламжлалт ажил болох хүний эрхийн боловсрол мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, тодорхой хүний эрхийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ, энэ чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн сүлжээг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллалаа.

### ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ

Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум 2010 оноос эхлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг механизмд мэдээллээ илгээх зорилгоор хамтран ажиллаж ирлээ. ННФ энэ цаг үеэс Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагааг дэмжиж ирсэн бөгөөд 2015 оноос бие даасан бүтэц болон бэхжих эхлэлийг тавьж үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь тус Форумын сар тутмын хурал болоод байна. Мөн үйл ажиллагаандаа баримтлах зарчим стандартыг тусгасан дүрмийн хэлэлцүүлгийг эхлүүллээ. Хүний эрхийн ТББ-уудын Форум нь НҮБ-ын хүний эрхийн механизмд мэдээлэл илгээх төдийгөөр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, хүний эрхийн хэрэгжилтэд системтэй, цаг тухайд нь мониторинг, үнэлгээ хийх тал дээр учир дутагдалтай байсан бол сар тутам хуралдах болсноор энэ чиглэлд тодорхой ахиц гарлаа.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Бүгд хурлаас 2015 оны 5 дугаар сард Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг дүгнэн хэлэлцээд өгсөн зөвлөмжийг эцэслэн баталсан бөгөөд Хүний эрхийн ТББ-уудын Форум тухайн сард нь UPR-Info Олон улсын ТББ-ын туслалцаатайгаар хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, стратегийн баримт бичиг боловсруулж 7, 10 дугаар сард Засгийн газрын холбогдох албаны хүмүүстэй зөвлөлдөж, Үйл

Хүний эрхийн ТББ-уудын Форум нь зөвхөн НҮБ-ын хүний эрхийн механизмд хандахаас гадна дотоодод болж буй хүний эрхийн асуудалд анхаарал хандуулж, хамтарсан нөлөөлөл хийж хэвшлээ.

ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулахаар саналаа өгөөд байна. Үүний дүнд хэрэгжилтийг нь үнэлэх боломжгүй төлөвлөгөөг иргэний нийгмийн оролцоогүйгээр баталж байсан практикийг өөрчлөх эхлэлийг тавилаа.

Түүнчлэн тус Форум UPR-Info, Форум Ази, Эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн төлөөх Азийн сүлжээ зэрэг олон улсын ТББ-тай хамтран хүний эрхийн асуудлаа НҮБ-ын хүний эрхийн механизмд хүргэж, нөлөөлөхөд тодорхой амжилт гаргасныг дурдах нь зүйтэй. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны хэлэлцэх асуудал, дүгнэлт зөвлөмжид Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын мэдээлэл бүхэлдээ тусгагдав.

ННФ нь Хүний эрхийн ТББ-уудын Форумыг бэхжүүлэх зорилгоор сургалт, уулзалт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, сар тутмын хурлаа зохион байгуулах, олон улсын хурал хэлэлцүүлэгт төлөөлөгч оролцуулахад техникийн туслалцаа үзүүлээ. Мөн түүнчлэн Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн мэдээлэлдээ тулгуурласан “Мэдээллийн хуудас” бэлтгэдэг туршлагыг Тайланд, Мьянмар Улсын иргэний нийгмийн байгууллага өөрсдийн нөлөөллийн үйл ажиллагаандаа авч ашигласан нь тус Форумын туршлагыг харуулсан видео бэлтгэх санааг төрүүлсэн тул богино хэмжээний видео бэлтгэж, түгээлээ.

ХҮНИЙ ЭРХИЙН ТББ - УУДЫН ФОРУМЫН 2015 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Үндэсний илтгэлийн талаар ХЗЯ, ГХЯ, бусад холбогдох төрийн байгууллагатай зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалтууд
- НҮБ-ын ХЭЗ-өөс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх стратеги, ажлын төлөвлөгөө боловсруулах цуврал уулзалт
- “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг II цикл” үндэсний зөвлөлдөх уулзалт

- МУ-ын Ерөнхий сайд, Хууль зүйн сайд, Гадаад хэргийн сайдад НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн Үндэсний илтгэлийн талаар мэдэгдэл; Халдашгүй дархан байх эрхийн зөрчилтэй холбогдуулан ХЗЯ, УЕПГ, ЦЕГ-т, Тахарын ерөнхий газрыг татан буулгахыг эсэргүүцэж УИХ-ын дарга, Ерөнхий сайдад, Хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн орчныг бий болгох асуудлаар УИХ, ЗГ, ХЗЯ-д тус тус шаардлага; Үндэсний статистикийн байгууллагын хараат бус, бие даасан байдлын талаар УИХ-ын дарга, Ерөнхий сайдад албан бичиг хүргүүлэв.
- МУ хүний эрхийн төлөв байдлаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн тухай иргэний нийгмийн мэдэгдэл гаргав.
- НҮБ-ын Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хорооны гишүүдтэй уулзаж, МУ дахь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийн мэдээллийг өгч, дүгнэлт зөвлөмжид тусгах саналаа хэлэв.

- Швейцарь Улсын Женев хотноо UPR-Info байгууллагын зохион байгуулсан НҮБ-ын ХЭЗ-ийн Ажлын хэсгийн хуралдааны өмнөх бэлтгэл хуралдаанд Хүний эрхийн ТББ-уудын Форумын 5 гишүүн байгууллага оролцож, мэдээлэл хийлээ.
- НҮБ-ын ХЭЗ-ийн Ажлын хэсгийн хуралдаанд Хүний эрхийн ТББ-уудын Форумын 2 гишүүн оролцов.
- НҮБ-ын ХЭЗ-ийн Бүгд хуралд Хүний эрхийн ТББ-уудын Форумын 2 гишүүн байгууллага оролцов.
- Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагааг үнэлж, цаашдын стратегийг хэлэлцэх уулзалт болов.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ

ННФ хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, нийгэмд хүний эрхийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх үйл явцыг байнга дэмжиж ирсэн бөгөөд зарим үйл ажиллагаа тогтмолжиж, агуулга болон хамрах хүрээ нь өргөжиж байна. Тухайлбал, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран зохион байгуулдаг “Хүний эрхийн олон нийтийн лекц”, “Хүний эрхийн тухай ярилцья” арга хэмжээ нь тогтмолжиж, тухайн цаг үеийн “халуун сэдэв”-үүдээр мэдлэг мэдээлэл солилцож, хэлэлцүүлэг өрнүүлдэг боллоо.

Үүний зэрэгцээ “Хүний эрхийн кино үдэш” арга хэмжээ 2015 оноос эхлэн улирал тутам зохион байгуулагдаж ирсэн бөгөөд цаазаар авах ялыг халах, эмэгтэйчүүдийн сонгох эрхийн төлөөх тэмцэл, хүний эрхийн хамгаалагчдын асуудал, эмэгтэйчүүдийн эрх, хувийн нууцыг хамгаалах, цахим аюулгүй орчны сэдвээрх кино үзэж, хэлэлцүүлэг өрнүүлсэн нь хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэхэд нэг чухал арга хэрэгсэл болоод байна. Тус арга хэмжээ нь их дээд сургуулийн багш, оюутнуудын сонирхлыг татсан, шинэлэг ажил байв. Түүнчлэн эдгээр үйл ажиллагаа нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг бий болгох, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ нийгэмд хүний эрхийн асуудлыг хойш тавих хандлага хүчтэй хэвээр байгаа үед энэ чиглэлийн үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

МОНИТОРИНГ

ННФ нь төрийн үйлчилгээнд мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагад бага хэмжээний тэтгэлэг олгох, энэ чиглэлээр ажиллах чадавхыг бий болгоход байнга анхаарч ирсэн билээ. Мониторингийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах болон аюулгүй чөлөөтэй орчинд зорчих эрхийн хэрэгжилт, Нийгмийн халамжийн тухай хуулийн “Зорилтот бүлгийн 3 ба түүнээс дээш тооны бага насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийг халамжид хамруулах” заалтын хэрэгжилт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх”- эд мониторинг хийх 3 төсөл шалгарч, бага хэмжээний тэтгэлэг аваад ажиллаж байна.

2015 онд эмзэг бүлгийн эрхийн хэрэгжилт, тэдэнд төрөөс үзүүлж буй үйлчилгээ, түүний чанар, үр нөлөө болон хүний эрхийн тодорхой асуудлаарх төрийн бодлого, түүний хэрэгжилтэд мониторинг хийх төслийн уралдаан зарлаж 3 байгууллага шалгаран ажиллаж байна.

I - II УЛИРАЛД

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН НИЙТИЙН ЛЕКЦ

- “Харьцуулсан эрүүгийн эрх зүй дэх хүний эрх”, Д.Баярсайхан, МУИС-ХЗС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Доктор, Профессор
- “Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал: Уламжлалт морин уралдаан ба хүүхдийн эрхийн асуудал”, Б.Гүнбилэг, ХХ-ны ОУЭЗХ-ны тэргүүн, өмгөөлөгч, Доктор
- “Шударга шүүхээр шүүлгэх эрх”, Н.Лүндэндорж, ШЕЗ-ийн дарга, Доктор, Профессор
- “Хүний эрхийн заалтыг тайлбарлах нь”, О.Мөнхсайхан, МУИС - ХЗС, Доктор, Дэд профессор

“ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЯРИЛЦЬЯ” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- “Тогтвортой хөгжлийн зорилго”, Чиглүүлэгч: Л.Төр-Од, Транспаренси интернэшнл
- “Шүгэлдэгч”, Чиглүүлэгч: Х.Наранжаргал, Глоб интернэшнл төв ТББ
- “Захиргааны ерөнхий хууль”, Чиглүүлэгч: П.Одгэрэл, МУИС-ХЗС-ийн багш, Доктор, Профессор, Хуулийн төслийн ажлын хэсгийн зөвлөх
- “Химийн бодис бидний амьдралд”, Л.Долгормаа, Байгаль орчин эрүүл мэнд төв ТББ
- “Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтад цагаан будааг түшиглэн мониторинг хийх, энэ чиглэлээр иргэдийн мэдэх эрхийг хангах”, Г.Оюунтуяа, Хэрэглэгч сан, Хүнс эвсэл ТББ

2015  
ҮЙЛ ЯВДАЛ

III-IV УЛИРАЛД

Доорх зургуудад “Хүний эрхийн тухай ярилцья”, “Хүний эрхийн кино үдэш” цуврал үйл ажиллагааны явцаас харуулав, Нээлттэй Нийгэм Форум, 2015 он. Гэрэл зургийг Э.Сайнтувшин, Б.Мөнхгэрэл

I - II УЛИРАЛД



III - IV УЛИРАЛД



ХҮНИЙ ЭРХИЙН КИНО ҮДЭШ

- “Үхдэл явж байна”, Найруулагч: Тим Роббинс; Гол дүрүүдэд: Сюзан Сарандон, Шон Пен
- “Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд”, Гол дүрүүдэд: Хилари Свенк, Франсе О’Коноор, Жулиа Ормонд, Моли Паркер, Лора Фазер, Брүүк Смиф, Вера Фармига, Луйз Смиф, Марго Матиндале, Анжелика Хюстен

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН НИЙТИЙН ЛЕКЦ

- “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Х.Наранжаргал, Глоб интернэшнл төв ТББ
- “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ба захиргааны хэргийн шүүх”, Ц.Цогт, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

ХҮНИЙ ЭРХИЙН КИНО ҮДЭШ

- “4 дэх иргэн”, Найруулагч: Лора Пойтрес, Дүрүүдэд: Эдуард Сноуден, Глен Гринволд, Жакоб Апплебаум, Эвен МакАскил, Лора Пойтрес
- “Мона Лизагийн инээмсэглэл”, Найруулагч: Майк Ньюэлл, Зохиолч: Лоуренс Коннер, Марк Росентал, Жүжигчид: Жулиа Робертс, Кирстен Данст, Жулиа Стайлс, Марша Гей Харден, Доминик Уэст, Мэгги Жилленхол, Женнифер Гудвин

“ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЯРИЛЦЬЯ” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- “1930-1940 оны улс төрийн хэлмэгдлийн үр дагавар”, Д.Дашдаваа, “Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд” ТББ
- “Цэнхэр сав буюу аюул дагуулсан хэрэглээ”, Чиглүүлэгч: Р.Нямдорж, Заша өвс ТББ
- “Ураны уурхай - Хүний эрх”, Чиглүүлэгч: Л.Бор, Их Бага баяншарга төвийн тэргүүн
- “Хүний эрхийн тухай ярилцья өглөөний уулзалтын дүгнэлт, хэлэлцүүлэг”, Чиглүүлэгч: Ч.Алтангэрэл, ХЭҮК-ын Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга

## ТЕАТР ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ

Хүний эрхийн тухай боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх нэг чухал арга хэрэгсэл нь урлаг, театрын үзүүлбэр юм. Тиймээс ННФ нь Глоб Интернэшнл Төв ТББ-ын санаачилсан “тавилттай уншлага” хэмээх үзвэрийн шинэлэг төрлийг хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, тулгамдсан асуудалд шийдвэр гаргагчид, олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор 2014 оноос эхлэн “Театр хүний эрхийн төлөө” санаачилгыг хэрэгжүүллээ.

Уг санаачилгын хүрээнд УДЭТ, Глоб Интернэшнл төв ТББ-тай хамтран 2015 онд нийт 11 аймгийн уран бүтээлчид, иргэний нийгмийн төлөөллийг жүжгийн зохиол бичих сургалтад хамруулснаас 8 аймаг тодорхой сэдвээр жүжгийн зохиолуудаа ирүүлсэн юм. Үүнээс 5 жүжгийг орон нутгийн театрт тоглох боломж олгож, шалгарсан 3 бүтээлийг олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан УДЭТ-ын тайзнаа тоглууллаа. Энэ нь орон нутгийн театр, иргэний нийгмийн байгууллагад “тавилттай уншлага”-ыг ашиглан хүний эрхийн нөлөөлөл, хамгаалал хийх чадавхыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан үйл ажиллагаа болов.



“Театр хүний эрхийн төлөө” төсөлд шалгарсан Дархан-Уул, Дорноговь, Архангай аймгуудын драмын театрын жүжигчид УДЭТ - т Гала тоглолтоо хийсний дараа, 2015 оны 12 сарын 16. Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл

## ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийг ННФ байнга дэмжиж, шаардлагатай тохиолдолд техникийн туслалцаа үзүүлж ирсэн билээ. 2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилгоор ХЗЯ-тай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж ажилласан бөгөөд энэхүү Санамж бичгийн хүрээнд тусгагдсан шинээр байгуулагдсан хууль сахиулах албадыг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, дотоод дүрэм журмаа хүний эрхийн зарчим стандартад нийцүүлэхэд нь дэмжлэг үзүүллээ.

### ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛД САНАЛ ӨГӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэг талаас, эрчимтэй өрнөж буй эрх зүйн шинэчлэлд иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх; нөгөө талаас, шинэчлэгдэн буй эрх зүйн орчныг иргэний нийгэмд таниулах зорилгоор “Хуулийн хэлэлцүүлэг” арга хэмжээг 2013 оноос санаачлан эхлүүлсэн юм. Энэ онд “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хууль”, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлгийг тус тус хийж, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нэгтгэн “Хуулийн шүүмж” боловсруулж, хуулийн төсөл боловсруулагчдад хүргүүллээ. Түүнчлэн, хуулийн төсөлд олон улсын эрдэмтэн, судлаачдын байр суурийг сонсох зорилгоор АНУ-ын Ст.Томас их сургуулийн профессор Жоханн Сейгфрэйд, Силвэр Жэй Стерлинг нарыг урьж “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуулийн төслийн ажлын хэсэгтэй уулзуулж, иргэний нийгмийн байгууллагатай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан хуулийн төсөлд санал авав. Үүний зэрэгцээ ННФ-ын ажилтнууд зарим хуулийн төслийн ажлын хэсэгт орж ажилласнаар хуульд хүний эрхийн зарчим стандартыг тусгахад түлхэц боллоо. Тухайлбал, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонголын тухай хуулийн ажлын хэсэгт орж ажиллан, шийдвэр гаргах явцад иргэний оролцоог хангах зохицуулалтыг тусгуулахад хувь нэмрээ орууллаа.

### ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ННФ нь хуулийн төсөл боловсруулах явцад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарахын зэрэгцээ шинээр батлагдсан хуулийг иргэний нийгмийн байгууллагад танилцуулах, энэ чиглэлээр мониторинг хийх чадавхыг бий болгох чиглэлээр анхаарч ажиллаж байна. 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг УИХ-аас баталсан бөгөөд тус хууль нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг анх удаа стандартчилж, иргэдийн оролцоог бодитоор баталгаажуулж өгснөөрөө Монгол Улсын хувьд түүхэн чухал үйл явдал юм. Захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь оролцоог хангадаггүй, дур зоргоороо авирлахыг хязгаарлаагүйн улмаас иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөж, сэтгэл санаа, эд материалын хохирол амсах явдал түгээмэл гардаг ч үүний төлөө захиргааны байгууллага хариуцлага хүлээдэггүй байсан практикийг халахад тус хууль чухал үүрэг

гүйцэтгэнэ. Хэдий хуультай болсон ч энэ талаар иргэд, иргэний нийгмийн байгууллага мэдэхгүй байх нь хуулийн үр нөлөөг бууруулах эрсдэлтэй тул ННФ тус хуулийг иргэний нийгмийн байгууллагад танилцуулах сургалт, тус хуулийг орон нутагт заах сургагч багш бэлтгэхэд анхаарч ажиллалаа.

Эрх зүйн шинэчлэлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд хариуцлагатай, чадварлаг иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг маш чухал билээ. Тиймээс ННФ-аас орон нутагт иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, аливаа асуудлаар өөр хоорондоо үр дүнтэй хамтран ажиллах эхлэлийг тавих зорилгоор аймгууд дахь ТББ-ын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг баруун болон төвийн бүсийн 10 аймгийг хамруулан бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан юм. Тус сургалтаар хүний эрхийн тухай ойлголт, хүний эрхийн зөрчлийн баримтжуулалтын талаар анхан шатны мэдэгдэхүүн өглөө. Мөн хүний эрхийг хамгаалах хэрэгслүүд болох мониторинг, стратегийн өмгөөлөл, нөлөөллийн цогц үйл ажиллагааны талаар анхан шатны мэдэгдэхүүн олгож, эрх зүйн шинэчлэл, тэр дундаа хууль сахиулах салбарын шинэчлэлийн талаар мэдээлэл өгөх зэргээр хамтран ажиллалаа. Энэхүү сургалт нь зөвхөн нэг удаагийн арга хэмжээ бус чадавхыг бэхжүүлэх чиглэлээр цогц хандлагаар ажиллах эхлэл алхам юм. Тухайлбал, цагдаагийн албаны шинэчлэлийн хүрээнд багаараа туршилтын мониторинг хийх боломжийг энэ онд олгосон билээ. Энэ нь танхимд сурсан зүйлээ практикт ашиглах, ТББ-ууд тодорхой асуудлаар хамтран ажиллах эхлэлийг тавьснаараа ач холбогдолтой болов.

### МОНИТОРИНГ

Энэ онд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 27 төсөл ирүүлснээс олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөрийн гэрээг дүгнэх ажиллагаа, Цагдаагийн албаны тухай хуулийн 14.1.2-р заалт болон тус хуулийн 21-р зүйлийн үүргийн хэрэгжилтэд тус тус мониторинг хийх гурван ТББ-д бага хэмжээний тэтгэлэг олголоо. Бидний стратегийн нэг чухал зорилт бол шинэчлэлийн үйл явцыг мэдээллээр хангах явдал тул нийслэл болон 9 аймагт ажиллаж буй цагдаагийн албаны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Иргэний зөвлөл, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаанд хийсэн мониторингийн дүнд тулгуурлан “Монитор”, “Бодлогын асуудал” бэлтгэж, холбогдох талуудад хүргэлээ. Эдгээр мониторингийн дүнг товч дурдвал Иргэний зөвлөл, Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаа жигдрээгүй, орон нутгийн удирдлагын зүгээс дэмжлэг бага, төсөв, санхүүжилт хангалтгүйгээс харилцан адилгүй урамшуулал олгодог, зарим аймаг санхүүжилтийг зогсоосон, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломж олгоогүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн юм.

### ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛЭЭР ГАРГАСАН ХЭВЛЭН НИЙТЛЭЛ



### I - II УЛИРАЛД

- “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлгийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл”-тэй хамтран зохион байгуулав.
- “Хохирлын сангийн тухай”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай” болон “Гүйцэтгэх ажлын тухай” хуулийн төслүүдэд санал хүргүүлэв.
- Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Орхон, Завхан, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Увс, Сэлэнгэ аймгийн ТББ-уудын 40 гаруй ажилтан оролцсон хүний эрхийн нөлөөлөл, хамгаалал хийх чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг Ховд, Орхон аймагт бүсчлэн зохион байгуулав.
- Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гэрч хохирогчийг хамгаалах, шүүх, шүүхийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий шинээр байгуулагдсан Тахарын албыг татан буулгах шийдвэрийг эсэргүүцэж, иргэний нийгмийн байгууллагатай хамтарсан нөлөөллийн ажиллагаа явууллаа.



- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд санал авах зорилгоор АНУ-ын Ст.Томас их сургуулийн хоёр профессор Монгол Улсад ажиллав.
- Хууль сахиулах салбарт мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, энэ салбарт ажиллах иргэний нийгмийг нэмэгдүүлэх зорилгоор туршилтын мониторингийг сургалтад хамрагдсан 10 аймгийн ТББ-ыг оролцуулан зохион байгууллаа. Тус мониторингоор цагдаагийн албаны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй Иргэний зөвлөл, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон нийтийн цагдаагийн ажилтны эрх зүйн орчин, хэрэгжилтэд үнэлгээ хийсэн юм.
- “Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн зарим асуудал” хэлэлцүүлгийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яамтай хамтран зохион байгууллаа.
- “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулав.
- “Захиргааны ерөнхий хуулиар орон нутагт сургалт зохион байгуулах сургагч багш бэлтгэх” сургалтыг нийслэл, 21 аймгийн ТББ-уудад зохион байгуулав.

### III-IV УЛИРАЛД



## ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Нээлттэй Нийгэм Форумын 2013-2016 оны үйл ажиллагааны стратегид шүүх эрх мэдлийн хүрээнд гарсан шинэтгэл амьдралд хэрэгжих явцыг хөндлөнгөөс ажиглаж хяналт тавих, судалгаанд үндэслэн бодлогын зөвлөмж боловсруулах замаар гарч болох алдаа дутагдлыг засаж залруулах зорилго тавьсан юм. Ингэхдээ сонирхогч талууд болон олон нийтийн оролцоог хангаж ажиллахыг зорилоо.

### ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛ

Шүүх эрх мэдлийн хүрээнд олон чухал шинэтгэл хийгдэж байгаа ч энэ явцад тодорхой бэрхшээл учирч байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал, Үндсэн Хуулийн Цэцээс Шүүхийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Шүүх байгуулах тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчиж байна гэж үзсэн 8 удаагийн шийдвэр гарсан нь шүүхийн тогтолцооны шинэтгэлийн хувьд ухралт болсон төдийгүй, төсвийн хувьд дарамт учруулж байна. Мөн шүүхийн бие даасан байдлын чухал баталгаа болох шүүхийн төсвийн бие даасан байдалд халдах гэж хууль тогтоогчид оролдсон нь шүүхийн хараат бус байдал эрх зүйн хувьд бүрэн баталгаажих чадаагүй байгааг харууллаа. Нөгөөтээгүүр, эдгээр үүссэн нөхцөл байдлыг шүүхийн тухай багц хуульд байгаа аливаа алдаа мэдгийг цаг алдалгүй засаж залруулах, дэвшилтэт үзэл баримтлалыг бататган бэхжүүлэх боломж гэж харж болно.

Шүүхийн сонгон шалгаруулалт болон томилгооны үйл явц шударга, ил тод байх нь шүүхийн хараат бус байдлыг хангах суурь нөхцөлүүдийн нэг юм. Дагнасан шүүх байгуулахтай холбоотойгоор шүүгчийн тоог нэмэх шаардлагатай болсон бөгөөд Шүүхийн Ерөнхий Зөвлөл (ШЕЗ) -өөс шүүгчийг сонгон шалгаруулж томилуулах үйл ажиллагааг шинэ эрх зүйн орчин, журмаар зохион байгуулж байгаа хэдий ч засаж сайжруулах, нарийвчлан зохицуулах асуудал байсаар байна.

Дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан ННФ - аас шүүхийн шинэтгэлийн үйл явцад дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх зорилгоор судлаачдын дунд бодлогын шинжилгээний төслийн уралдаан зарлаж (i) “Шүүгчийн хараат бус байдлын баталгааны хэрэгжилт”, (ii) “Шүүгчийн томилгооны

**ННФ судлаачдын дунд шүүхийн шинэтгэлийн үйл явцад дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх бодлогын шинжилгээний төслийн уралдаан зарлаж 4 сэдвээр судалгаа хийлгэн үр дүнг олон нийтэд хүргэлээ.**

өнөөгийн нөхцөл байдал”, (iii) “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт”, (iv) “Шүүхийн захиргааны тулгамдсан асуудал ба шийдвэрлэх арга зам” гэсэн сэдвүүдээр судалгаа хийлгэн үр дүнг олон нийтийн хүртээл болгоод байна.

## ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ



Шүүгчийг сонгон шалгаруулах, томилох үйл явцад оролцдог субъектүүдийн гүйцэтгэж буй үүргийг тусган процессын зураглал гаргах, шүүгч хуульчдын өргөн хүрээний санал асуулга, тодорхой тохиолдлыг шинжлэн тулгарч буй асуудлыг тодорхойлохыг зорьжээ.



Үндсэн хууль зөрчсөн гэж удаа дараа шийдвэрлэгдэж байгаа шүүхийн тойргийн тогтолцооны талаар Төв аймгийн жишээнд суурилан олон талын байр суурь, тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлон бодлогын Зөвлөмж боловсруулжээ.



МУ-ын шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах өнөөгийн нөхцөл байдлыг олон улсын нийтлэг жишигтэй харьцуулах, шүүгч, хуульч, иргэдийн санаа бодлыг тандан судалж бодлогын Зөвлөмж гаргажээ.



ШЕЗ нь шүүх эрх мэдэлтэй холбоотой бодлого, шүүхийн менежмент, төсөв, шүүгчийн шалгаруулалт, гүйцэтгэлийн үнэлгээ, ёс зүй, сахилгатай холбоотой чиг үүрэг, түүнийг дагасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр 2012 оны Шүүхийн тухай багц хуульд заасан. МУ-ын ШЕЗ бусад улсынхтай харьцуулахад илүү өргөн эрх мэдэлтэй ба шүүхийн захиргааны бараг бүх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлж эсхүл хэрэгжүүлэхэд оролцдог. Энэ нөхцөл байдлыг харгалзан МУ дахь шүүхийн захиргааны загварын тулгамдсан асуудлыг тоймлон тодорхойлж, шийдвэрлэх арга замыг санал болгожээ.

Дэлгэрэнгүй тайлан болон бодлогын зөвлөмжийн хураангуйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.

## ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ

2014-2015 онд хийж гүйцэтгэсэн шүүхийн ажиглалтын дараа түүний үр дүнг шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад танилцуулах, улмаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад нөлөөлөх зорилгоор нэгдсэн тайланг хэвлүүлэн бүх шатны шүүхэд хүргүүлжээ.

Түүнчлэн ШЕЗ-ийн ажлын албатай хамтран ажиглалтад хамрагдсан орон нутгийн шүүхийн шүүгчидтэй цахим хурлын төхөөрөмжийн тусламжтайгаар онлайн уулзалт хийлээ. Мөн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид болон захиргааны ажилтнуудын төлөөлөлтэй биечлэн уулзаж ажиглалтын мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар ярилцаж санал солилцов. Нөлөөллийн ажлын үр дүнд ШЕЗ-өөс шүүхийн ажиглалтын үр дүнг анхааралдаа авч үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллахаар болсон ба энэ нь шүүхийн зүгээс аливаа хөндлөнгийн мониторинг, судалгааны дүнд нээлттэй, ажил хэрэгчээр ханддаг болсныг харуулж байна.

Шүүхийн ажиглалтын арга зүйг түгээн дэлгэрүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудыг идэвхжүүлж, ажиглалтын арга зүйг эзэмшүүлэх нь шүүхийн нээлттэй, хариуцлагатай, хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Иймд 9 аймгийн 34 ТББ-ыг хамруулсан гурав хоногийн арга зүйн сургалтыг бүсчлэн зохион байгууллаа. Орон нутгийн иргэдийн хувьд шүүхийн үйл ажиллагааг зөвхөн гэмт хэрэг, асуудалд холбогдсон хүмүүст хамаатай мэтээр сүрдэх хандлага байдаг байна. Зүүн бүсийн сургалтыг Хэнтий аймагт, говийн бүсийн сургалтыг Өмнөговь аймагт тус тус зохион байгуулсан бөгөөд сургалтын хүрээнд орон нутгийн шүүхийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулсан нь шүүхийн шинэтгэлийн мөн чанарыг тайлбарлан таниулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Мөн Улаанбаатар хотын сонирхсон 17 төрийн бус байгууллагыг хамруулан арга зүй танилцуулах хоёр өдрийн сургалт зохион байгууллаа.

Орон нутгийн төрийн бус байгууллагуудад сургалтаар олж авсан мэдлэгээ амьдралд туршиж баталгаажуулахад нь дэмжлэг болох зорилгоор хоёр сарын хугацаатай дадлага төслийн тэтгэлэг олгов. Дадлага төслийн хүрээнд сургалтад хамрагдсан төрийн бус байгууллагын төлөөллүүд аймаг тус бүрээр баг болон тухайн аймгийн анхан шатны шүүхэд ажиглалт хийж доорх сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулж ажиллалаа. Үүнд:

- Шүүх хуралдааны тов
- Шүүх хуралдааны нээлттэй байдал
- Шүүхийн шийдвэрийн нээлттэй байдал
- Шүүх хуралдааны зохих үе шат мөрдөгдөж байгаа эсэх.

Дадлагын хугацаанд цуглуулсан мэдээлэлд эрх зүйн хувьд дүн шинжилгээ хийн тайлан боловсруулах ажлыг эрх зүйн судалгааны “Оюуны Инноваци” ТББ-тай хамтран гүйцэтгэлээ. Энэхүү хамтын ажиллагаа нь байнгын мониторинг, ажиглалт явуулах боломжит хувилбарыг туршиж зорилгыг давхар агуулж байв. Энэхүү ажлаар орон нутагт байнгын ажиглалт хийж мэдээлэл цуглуулах бололцоогүй мэргэжлийн судалгааны байгууллага болон цуглуулсан мэдээлэлдээ мэргэжлийн түвшинд анализ хийх чадавх хомс орон нутгийн иргэний нийгмийн байгууллагыг холбосноор өргөн хүрээнд ажиглалт хийх боломж бүрдүүлэхийг зорилоо.

ННФ 2010 болон 2014 онд шүүхийн ажиглалтыг хууль зүйн клиник сургалтын төвүүдтэй хамтран хэрэгжүүлсэн бөгөөд клиник төвд суралцагч ахлах ангийн оюутнууд ажиглагчаар оролцсон нь уг төслийг судалгаа шинжилгээнээс гадна практик сургалтын хувьд ач холбогдолтой болгосон юм. Цаашид шүүхийн ажиглалтыг системтэйгээр тогтмол хэрэгжүүлэхэд стратегийн хувьд чухал түнш болох хууль зүйн клиник төвүүдэд шүүхийн ажиглалтыг сургалтын арга хэлбэр болгон нэвтрүүлэхэд нь дэмжлэг болох үүднээс Улаанбаатар хотноо үйл ажиллагаа явуулж байгаа хууль



ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа Шүүхийн ажиглалтын тайланг Хөвсгөл, Дорнод, Төв аймгийн шүүхийн ажилтнуудад видео хурлаар танилцуулж байгаа нь 2015 оны 5 сарын 20, Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл

зүйн 9 сургуулийн клиник сургалтын төвийн багш нарт арга зүйг танилцуулах нэг өдрийн семинар зохион байгууллаа.

Эдгээр арга хэмжээг бататгах, оролцогчдыг идэвхжүүлэх үүднээс сонирхсон дөрвөн сургуульд шүүхийн ажиглалтыг практикт сургалтад туршихад нь тэтгэлэг олгосноор хууль зүйн клиник төвүүд өөрсдийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн 2-6 сарын хугацаатайгаар төслийг хэрэгжүүлж туршсан болно. Цаашид суралцагчдын судалж буй хичээлийн сэдэвтэй уялдуулан шүүх хуралдаанд ажиглалт хийх боломжтой нь төслийн үр дүнгээс харагдаж байна.

Монгол Улсын “Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт”-д заасны дагуу эрх зүйч бэлтгэж байгаа их дээд сургуулиудыг клиник сургалтын төвтэй байхыг шаарддаг бөгөөд тус стандартын С хавсралтаар клиник төвд тавигдах стандартыг баталсан байдаг. Хууль зүйн клиник төвүүдийг бэхжүүлэх зорилгын хүрээнд эрх зүйч бэлтгэж буй 7 сургуулийн клиник төвийн үйл ажиллагаанд мониторинг хийж тэдний материаллаг бааз, сургалтын чанарыг үнэллээ. Мониторингийн дүнгээс харахад клиник төвд шаардлагатай өрөө тасалгаа, сургалтын хэрэглэгдэхүүний хангалт муу, туршлагатай клиникийн багш хүрэлцээгүй байна. Гэсэн хэдий ч сургуулиудын удирдлагын зүгээс клиник сургалтын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч дэмжих хандлага нэмэгдэж байгаа нь сайшаалтай.

### ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ

Шүүхийн тухай багц хуулийн хүрээнд батлагдсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль” нь шүүхийн хараат бус, нээлттэй байдлыг хангах механизмыг хуульчилсан чухал алхам болсон билээ. Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн цэцээс энгийн иргэдийн оролцоотойгоор шүүхэд хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг Үндсэн хуульд харшилж байна гэж үзсэн тул хуулийг дахин шинэчлэн найруулах шаардлага гарсан юм. Иргэдийн шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхтэй холбоотой асуудлаас гадна иргэдийг тохиолдлын журмаар оролцуулах ажлыг зохион байгуулах, сонгогдсон иргэдийг сургах асуудал нэг мөр болж чадаагүй байна.

Форумын зүгээс шүүхийн иргэдийн төлөөлөгчийн механизмд онцгой анхаарал хандуулж ирсэн бөгөөд 2015 онд сонгогдсон иргэдэд эрүү, иргэн, захиргааны шүүхийн процесс, хуулийн нэр томъёог энгийн ойлгомжтой хэлбэрээр тайлбарласан мэдээллийг мэдлэг шалгах асуулгын хамт боловсруулж шүүхийн захиргаанд болон ШЕЗ-д хүргүүллээ. Мөн уг видеог Монголын үндэсний олон нийтийн телевизээр гаргасан нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар иргэдийн дунд тодорхой ойлголт өгсөн гэж найдаж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга эцэслэн батлагдах үйл явц удаашралтай байсан тул шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгож, бэлтгэн шүүх ажиллагаанд оролцуулах ажлыг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий шүүхийн захиргааны

**Олон нийтэд зориулан шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг, оролцооны талаар танилцуулга видео бэлтгэн бүх аймгийн шүүхэд хүргүүлж, орон нутгийн телевизүүдээр гаргав.**



ажилтнуудтай хуулийн хэрэгжилтийг хангах, үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа. Энэ хүрээнд шүүхийн дотоод зохион байгуулагч нарын дунд санал асуулга явуулж, ШЕЗ-ийн ажлын албатай хамтран хоёр өдрийн сургалт семинар зохион байгуулсан нь нэн хэрэгцээтэй, цаг үеэ олсон арга хэмжээ болж чадсан. Арга хэмжээний үеэр дотоод зохион байгуулагч нарын практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ур чадварын сургалт явуулахын зэрэгцээ тэдний өдөр тутмын ажил үүрэг, тэр дундаа шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хангахтай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж тодорхой саналыг нэгтгэн ШЕЗ-ийн ажлын албанд хүргүүлээд байна.

Зүүн гар талд шүүхийн иргэний төлөөлөгчдөд зориулан Хэнтий, Өмнөговь аймгууд болон Улаанбаатар хотод зохион байгуулсан цуврал сургалтын зургуудаас харуулав.  
Дээрээс доош: Өмнөговь аймгийн Шүүхийн хуралдааны зарлалын самбар, Хэнтий аймгийн Шүүхийн зохион байгуулагч Т. Ариунболд шүүхийн танхимаа танилцуулж байгаа нь, Өмнөговь аймагт зохион байгуулсан “Шүүхийн үйл ажиллагаанд мониторинг хийх арга зүйг иргэний нийгмийн байгууллагад эзэмшүүлэх нь” сургалтын үеэрх бүлгийн ажил, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Шүүхийн дотоод зохион байгуулалт хариуцсан ажилтнуудын сургалтын явц, 2015 оны 8 ба 12 дугаар сар Гэрэл зургийг Б.Үүрийнтуяа

## УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Монгол Улсад ардчилсан хувьсгал ялснаар нэг намын тогтолцоог халж иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах зарчимд суурилсан олон намын тогтолцоо бүрэлдэн тогтсон билээ. Энэ цаг үеэс хойш улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт өөрчлөлт, шинэчлэлт эрчимтэй өрнөсөөр ирсэн боловч улс төрийн нам, улс төр дэх мөнгөний харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин төдийлөн шинэчлэгдсэнгүй. Энэ байдал нь улс төрийн үйл явцыг гажуудуулж, улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлөхийн сацуу сонгууль шударга бус явагдах нөхцөлийг бүрдүүлж, нөгөө талаасаа авлига бий болох хөрс суурь болдог нь олон улсын туршлагаас тодорхой харагддаг. Сүүлийн үед хийгдсэн янз бүрийн судалгааны тайлан, баримт бичгүүдээс үзэхэд улс төрийн намууд нь манай улсад хамгийн авлигад өртсөн болон өртөх эрсдэлтэй институцид тооцогдож байгаа ба сонгуулийн жилүүдэд кампанит ажлын санхүүжилттэй холбоотой зөрчил гомдол тасрахгүй байгаа нь энэ талаарх зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна. 2014 онд Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр Сант Марал Сан хот, хөдөөгийн нийт 1200 хүнийг хамруулан хийсэн улс төрийн санхүүжилтийн талаарх иргэдийн санал бодлын судалгааны тайланд иргэдийн 79 хувь нь сонгуулийн болон намын санхүүжилттэй холбоотой хуулийн ихэнх заалт хэрэгждэггүй гэж үзсэн байх ба улс төрийн санхүүжилтийн өнөөгийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байгааг 86 хувь нь онцолжээ. Цаашид ардчилсан тогтолцоонд амин чухал үүрэгтэй улс төрийн намын институцийн төлөвшил, хөгжлийг дэмжих хүрээнд улс төр болон бизнес, мөнгөний харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчныг бий болгох шаардлага зайлшгүй тулгамдаж байна.

ННФ нь 2004 оноос эхлэн сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн мониторинг, нөлөөллийн үйл ажиллагааг судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан явуулж эхэлсэн. 2014 оноос энэ чиглэлээр хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаагаа өргөжүүлж улс төрийн санхүүжилтийн асуудлыг стратегийнхаа нэг гол зорилт болгон тусгасан ба энэ чиглэлээр мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, одоо үйлчилж буй хуулийн хүрээнд улс төрийн санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд ил болгоход дэмжлэг үзүүлэх, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчинд үнэлгээ хийх, зөвлөмж гарган бодлого боловсруулагчдад хүргэх үйл ажиллагааг шат дараалалтай явуулж ирлээ.

**Хот, хөдөөгийн 1200 хүнийг хамруулсан судалгаагаар улс төрийн санхүүжилтийн өнөөгийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байгааг нийт оролцогчдын 86 хувь нь онцолжээ.**

## ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

УИХ-аас Сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан билээ. ННФ-ын зүгээс энэ хуулийн төслийг боловсруулах үйл явцад талуудын оролцоог хангаж байр суурь, санал бодлоо хуваалцах боломж олгох зорилготой цуврал хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдлаа.

ННФ нь 2015 оны 4 дүгээр сараас эхлэн Сонгуулийн хуулийн шинэчлэлтэй холбоотой нийт таван удаа хэлэлцүүлэг зохион байгуулснаас гурав нь сонгуулийн санхүүжилтийн асуудлыг тал бүрээс нь нухацтай авч үзэхэд чиглэв. СЕХ-ны мэдээллээс харахад улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал сонгуулиас сонгуульд байнга огцом өсөж иржээ. Сонгуулийн зардал хэт өндөр байх нь иргэд Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхээ чөлөөтэй эдлэхэд саад болоод зогсохгүй нам, нэр дэвшигчид нь чинээлэг хандивлагчид, бизнесийнхнээс хараат болж улмаар авлига авах, сонирхлын зөрчилд автахад хүргэдэг сөрөг нөлөөтэй.

Эдгээр хэлэлцүүлгийн явцад дараах тодорхой асуудлаар судлаачид илтгэл тавьж, оролцогч талууд санал бодлоо солилцсон юм. Үүнд:

- Сонгуульд оролцож буй улс төрийн нам, нэр дэвшигчдийн кампанит ажлын санхүүжилтийн эх үүсвэр (хандив, өөрсдийн хөрөнгө, төрийн санхүүжилт), тэдгээртэй холбогдон үүсэж буй асуудлууд



ННФ-аас зохион байгуулсан хэлэлцүүлэгт илтгэл тавьсан Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн, судлаач С.Оюунтуяагийн дурдсанчлан:

“1992 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажилд нам, нэр дэвшигчдийн зарцуулсан мөнгө 13,7 сая төгрөг буюу нэг хүнд 13 төгрөг ногдож байжээ. Харин энэ тоо 2012 оны УИХ-ын сонгуулиар 36 тэрбум давсан байна. Энэ мөнгөний ихэнх нь эрх баригч намуудад хамаарна. Нэг нэр дэвшигчид ногдох зардлын дүн 2008 онд 22,7 сая төгрөг байсан бол 2012 онд 104 болж тав дахин өсжээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн кампанит ажлын зардал ч мөн 2009 онд 4,9 сая төгрөг байсан бол 2013 онд 3 дахин өссөн” байна.

- Зардлыг бууруулах арга зам, үр нөлөө (кампанит ажлын хугацаа, төрийн санхүүжилт /шууд, шууд бус, тавигдах шалгуур/, зардлын дээд хэмжээг тогтоон мөрдүүлэх)
- Сонгуулийн зардлыг хянахтай холбоотой хуулийн зохицуулалтууд, хэрэгжилтийн байдал
- Сонгуулийн санхүүжилт, зардалд үр дүнтэй хяналт тавихад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замууд
  - Зардлын данстай холбоотой зохицуулалтыг хэрхэн сайжруулах
  - Хяналтыг хэрэгжүүлэхэд аль тал ямар үүрэгтэй оролцох
  - Зардлын тайланг ил тод болгох асуудал (хугацаа, зардлын тайлангийн агуулга).

2015 оны 12 дугаар сард УИХ-аас батлан гаргасан Сонгуулийн тухай шинэ хуульд сонгуулийн кампанит ажлын зардлыг бууруулахад чиглэсэн зарим шинэлэг заалтууд туссан ч санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, хяналтыг сайжруулах талаар дорвитой өөрчлөлтүүд ороогүй. НҮБХХ зэрэг олон улсын судалгааны байгууллагуудаас гаргасан зөвлөмжид сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, хяналт тавих эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлж, хэрэгжүүлээгүй нөхцөлд сонгуулийн санхүүжилттэй холбоотой өөр ямар ч сайн зохицуулалт байгаад үр дүнгүй болохыг тэмдэглэсэн байдаг. Цаашид сонгуулийн зардалд тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүд хуульд зайлшгүй тусах шаардлагатай хэвээр байна.

### УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Сонгуулийн хуулийн шинэчлэлийг тойрсон дээрх хэлэлцүүлгээс гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр 2015 оны 7 дугаар сарын 24-нд иргэний нийгмийн төлөөлөл, бие даасан судлаачид болон парламентад суудалгүй намуудыг оролцуулсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулав. Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намуудын тухай хуулийг 1990 онд баталсан бөгөөд 2005 онд Улс төрийн намын тухай хууль болгон шинэчлэн найруулсан юм. Энэхүү хуульд улс төрийн нам байгуулах үйл явц, намын бүтэц, үйл ажиллагааны ерөнхий зарчмыг тодорхойлсон дэвшилттэй зохицуулалтууд тусгагдсан боловч намын дотоод ардчилал, үйл ажиллагааны ил тод байдал, үүнд ялангуяа намын санхүүжилтийн асуудал, түүнд тавих хяналтыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Ерөнхийлөгчөөс өргөн барьсан шинэ хуулийн төсөлд олон улсын чиг хандлагад нийцүүлэн улс төрийн намуудад төсвөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар томоохон хандивлагчдаас хараат бус байх нөхцөл бүрдүүлэх, санхүүжилтэд тавих төрийн болон олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх талаар заалтууд багтсан байв. ННФ-ын зохион байгуулсан хэлэлцүүлэгт хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүд оролцож дэлгэрэнгүй танилцуулга хийсэн ба оролцогчид улс төрийн нам байгуулах, татан буулгах, хариуцлага тооцохтой холбоотой заалтууд дээр онцлон шүүмжлэл өрнүүлж, санал бодлоо чөлөөтэй солилцов.

### УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нээлттэй Нийгэм Форумаас санаачлан санхүүжүүлж улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох ерөнхий зорилгын хүрээнд СЭЗДС-ийн багш, Доктор Б. Эрдэнэдалай “Улс төрийн намд олгож буй төрийн санхүүжилтийн зарим асуудал”, Хуульч, Улс төр судлаач Б. Долгор

нар “Улс төрийн намд хуулийн этгээдээс буюу аж ахуйн нэгж, байгууллагаас өгөх хандивын асуудал” сэдэвт судалгааг тус тус хийж гүйцэтгэлээ. Эдгээр судалгаанд томоохон бизнесийн байгууллага, хандивлагчид улс төрд нөлөө тогтоохоос хэрхэн сэргийлж, улс төр-мөнгөний харилцан хамаарлыг бууруулах, аж ахуйн нэгж байгууллагаас улс төрийн намд өгөх хандивын талаарх хуулийн зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох асуудлыг хөндөж, зөвлөмж гаргасан байна.

Тухайлбал, судлаач Б. Эрдэнэдалай улс төрийн намд төрөөс олгож буй дэмжлэг нь зөвхөн томоохон намуудад ашигтай байхаар зохицуулагдсан байгааг шүүмжлээд парламентад суудалгүй намууд, бие даан нэр дэвшигчид, эмэгтэй нэр дэвшигчдэд хүртээмжтэй байх өөр хэлбэрийн дэмжлэгийг нэвтрүүлэх шаардлагатай байгааг онцолжээ. Үүнд дараах хэлбэрийн дэмжлэг байж болохыг дурдсан байна:

- Зөвхөн УИХ-д суудал авсан нам бус, сонгогчдын тодорхой хувийн дэмжлэг авсан намд авсан саналынх нь хувьд үндэслэн урамшуулал олгох
- Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн намуудад тухайн намаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн тоотой уялдуулан тогтоох
- Нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын зардлын тодорхой хувийг татаас хэлбэрээр олгох
- Сонгуулийн сурталчилгааны мөнгөн бус санхүүжилт.

**УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АРГА ХЭРЭГСЭЛ**

**СЭТГҮҮЛЧДИЙН КЛУБ:** Улс төрийн санхүүжилтийн сэдвээрх мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол, үе шаттайгаар хүргэх, энэ сэдвээр сэтгүүлчдийн ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэх, улмаар улс төрийн санхүүжилтийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2014 онд байгуулсан сэтгүүлчдийн клуб 2015 онд үйл ажиллагаагаа үргэлжлүүлээ. ННФ-ын зүгээс сэтгүүлчдийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор эрэн сурвалжлах сэтгүүл зүйн болон авлигын асуудлаар олон улсын хурал, уулзалтад оролцож мэргэжил нэгтгүүдтэйгээ санал бодлоо солилцох бололмж олгов.

Клубийн гишүүд тогтмол уулзан сонгуулийн шинэ хууль болон улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад туссан өөрчлөлт, санхүүжилтийн ил тод байдал, хариуцлага, хяналтын механизмын талаар мэдээлэл солилцон судлаач, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран мэдээ нийтлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ирлээ.



**НАМУУДЫН САНХҮҮЖИЛТ ХААЛТТАЙ, ИЛ ТОД БИШ БАЙНА**

ELECTION BOX

**ШИЛЭН НАМ ВЭБСАЙТ:** Улс төрийн томоохон албан тушаалтнуудын хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдээлэл, нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан зэрэг мэдээллийг нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх зорилго бүхий [www.shilennam.mn](http://www.shilennam.mn) цахим мэдээллийн санг бий болгоход МИДАС ТББ-тай хамтран ажиллалаа. Энэхүү цахим хуудаснаас сонгуульд өрсөлдөж байсан намууд тухайн сонгуулийн жил хаанаас ямар хэмжээний хандив авсан мэдээллийг харьцуулж харах боломжтойгоос гадна бизнесийн аль салбараас түлхүү хандив авч байгааг мөн үзүүлэхийг зорьж байна. Энэ мэдээлэл ил болсноор бодлого боловсруулагчдын гаргаж буй шийдвэрт мөнгөний нөлөө хэрхэн тусаж буйг сонгогчид хянах боломжтой болох сайн талтай.



Зүүн гар талд: Клубийн гишүүн, Eagle телевизийн сэтгүүлч Ө.Золбаяр намуудын санхүүжилтийн сэдвээр асуудал хөндсөн нэвтрүүлэг хөтөлж буй нь, 2015 оны 9 дүгээр сар

## ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

### МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

#### МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын нөлөөлөл, хүчин чармайлтын дүнд 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдсан нь төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох, төрийн үйл ажиллагааны хариуцлагатай, ил тод байдлыг хангах улмаар төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол бүхий эрх зүйн орчин бүрдүүлсэн билээ. 2014 оны 7 сарын 1-нд Шилэн дансны хууль батлагдаж гарснаар дээрх хуулийн хоёр бүлэг хасагдаж харин төрийн байгууллагууд хүний нөөцийн болон үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг нийтэд ил болгох тухай зохицуулалт нь хэвээр үлдсэн.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22-р зүйлд Мэдээлэл, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэдээллийг цахим хэлбэрт оруулан хадгалах, түгээхтэй холбоотой бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан. Харин хуулийн хэрэгжилтийг хангах нийтлэг журмыг Засгийн газраас батлахаар зааж, зохицуулжээ. Бодит байдалд мэдээллийн үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам болон цахим мэдээллийг нийтэд ил болгох тухай нийтлэг журмаас өөр нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

ННФ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх зорилгоор үндэсний болон орон нутгийн төрийн бус байгууллагуудад мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж хамтарч ажиллалаа. Тэтгэлэгт төслийн хүрээнд Захиргааны шинэ санаачилга ТББ нийслэл хотын төвийн 6 дүүрэг, Өрнөх Хөгжил ТББ Завхан аймгийн 4 сум, Дундговь аймгийн Говийн хөгжлийн наран ТББ аймгийн төвийн хэмжээнд төрийн байгууллага мэдээллээ

ил болгож байгаа байдалд ажиглалт хийж олон нийт, төрийн албан хаагчдын дунд хуулийн талаар ойлголт мэдээлэл ямар байгааг судлан баримтжуулсан юм. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь төслийн үр дүнгээс харагдаж байна.

Энэхүү мониторингийн төсөл нь мэдээллийн ил тод байдлын нөхцөл

байдлыг нийслэл хот болон орон нутагт зэрэгцэн судалж баримтжуулснаараа онцлог байв. Түүнчлэн нэгдсэн байдлаар буюу хамтран үндэсний хэмжээнд нөлөөлөл хийх мэдээллийн бааз суурь бий болгосноороо эдгээр мониторинг нь илүү ач холбогдолтой боллоо гэж дүгнэж байна.

### Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ИРГЭД ЯМАР ОЙЛГОЛТТОЙ БАЙНА ВЭ? (Мониторингийн төслийн дүнгээс)



### Төслийн хүрээнд явуулсан санал асуулгын дүн



Завхан: 332 иргэнээс 91% нь мэдэхгүй  
УБ: 480 иргэнээс 77% нь мэдэхгүй  
Дундговь: 168 иргэнээс 62% нь мэдэхгүй

Дундговь аймагт хийсэн судалгаанаас харахад иргэдийн мэдээлэл авдаг суваг, төрийн байгууллагын мэдээлэл өгдөг суваг ялгаатай байгаа нь харагдав (Доорх графикийг харна уу).

Иргэдийн зүгээс мэдээлэл авахад учирч буй бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон байна (Доорх графикийг харна уу).



### ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ – ЦАХИМ ЭРХ ЧӨЛӨӨ

Мэдээллийн технологийн хурдтай хөгжлийг даган цахим мэдээллийн хэрэгсэл ашиглагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Ингэснээр интернэт орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууц, цахим аюулгүй байдалтай холбоотой олон шинэ сорилт гарч ирсээр байна. Нээлттэй Нийгэм Форум нь 2015 онд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар бодлогын судалгаа, шинжилгээ хийх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулж шинэлэг ойлголт, олон улсын чиг хандлагын талаар санал солилцох орон зайг бий болгоход анхааран ажиллалаа. Тухайлбал цахим орчинд, тэр дундаа цахим мэдээллийн хуудас, блог, сошиал мэдээллийн хэрэгслээр

дамжуулан иргэд үзэл бодлоо илэрхийлэх, цахим орчинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлын хүрээнд тодорхой сэдэв сонгон богино хугацааны судалгаа, бодлогын дүн шинжилгээ хийлгэхээр судалгааны төслийн уралдаан зарласан. Энэхүү уралдаан нь дээрх шинэлэг асуудлаар судалгаа хийх, баримт нотолгоонд суурилсан хэлэлцүүлэг өрнүүлэхэд дөхөм болохын зэрэгцээ тус салбарт шинэ тутам гарч ирж буй судлаачдыг хөхиүлэн дэмжих зорилго давхар агууллаа. ННФ - аас “Цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө ба нэр төртэй байх эрх” (Судлаач: Ч.Бат-Уянга), “Монгол Улсын цахим орчин дахь хувийн нууцын эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох нь” (Судлаач: Д.Мөнхбүрэн) судалгааг тус тус дэмжин хийлгээд байна.

2015 оны 5 дугаар сарын 4-5-нд Монгол Улсын Засгийн газар олон улсын “Цахим эрх чөлөө” эвслийн сайд нарын 5-р бага хурал Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх талаар идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлэх уур амьсгалыг бүрдүүлж өгсөн юм. Энэхүү арга хэмжээний өмнө буюу 2015 оны 5 дугаар сарын 3-нд тохиосон Олон улсын хэвлэлийн эрх чөлөөний өдөөр Глоб Интернэшнл төвөөс зохион байгуулсан олон улсын дугуй ширээний ярилцлагыг Форумын зүгээс дэмжин оролцлоо.

### ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЦАХИМ ОРЧИНД ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ АСУУДЛААРХ СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТЭЭС

Судлаач Ч.Бат-Уянга

Цахим орчинд хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах шаардлагын улмаас гэх тодотголтойгоор зарим хязгаарлалт (тухайлбал “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай тогтоол) төрийн зүгээс хийх болсон. Энэ нь зорилго талаасаа зөв мэт боловч хязгаарлаж буй арга хэрэгсэл нь өөрийн хязгаарлалтаасаа хэтэрч буюу хууль ёсны байх зарчмыг зөрчиж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэнд халдсан явдал боллоо.

Төрийн байгууллагууд тухайлбал, Харилцаа, холбооны зохицуулах хороо зэрэг үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээлэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд холбогдох газрууд үйл ажиллагаандаа тухайн эрхийг хангахад баримтлах зарчмуудыг мөрдөх явдал хангалтгүй байна. Энэ тохиолдолд Үндсэн хууль дахь үзэл бодлоо илэрхийлэх суурь эрхтэй холбоотой заалтыг олон улсын нэгдэн орсон баримт бичгүүдийн заалтын хамт тайлбарлан шүүхийн практикт хэрэглэдэг болох, түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахад баримтлах зарчмуудыг хууль тогтоох болон гүйцэтгэх түвшинд чанд баримталдаг болох шаардлагатай байна.

Судлаач Д.Мөнхбүрэн

Монгол Улсын цахим орчин дахь хувийн нууцын эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох асуудлыг тодорхойлсон энэхүү судалгааны дүнгээс харахад иргэдийн интернэтийн хэрэглээ өссөн хэдий ч цахим орчинд хувийн нууцаа хамгаалах мэдлэг, дадал сул байна. Цахим орчинд хувийн нууцаа хадгалах, хамгаалуулах нь олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичигт тодорхойлсноор орчин цагийн хүний эрхийн хэлбэрт тооцогдоно. Гэтэл төрийн албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлын ойлголт, мэдлэг, хэрэглээ хангалтгүй, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажилтнууддаа зориулсан сургалт мэдээлэл өгдөг тогтолцоо төлөвшөөгүй байна. Түүнчлэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид IP камер өргөн хэрэглэгдэж, үйлчлүүлэгчийн анкет мэдээлэл, мөнгө, хөрөнгө, даатгал, өргөдөл, хүсэлт зэрэг маш олон төрлийн мэдээлэл хадгалагдаж байгаа ч ажилтнуудтай нууцын гэрээ байгуулж хариуцлага тооцох, техник, тоног төхөөрөмжийн нууцлал, код, паспортыг шинэчлээгүйгээс хувийн орон зайд халдах, мэдээлэлд нэвтрэх боломж нээлттэй байна.

Технологийн хөгжил тасралтгүй үргэлжлэх, шинэ хэрэглээ ихсэх тутам иргэдийн мэдлэг, хандлага нь түүнийг дагаж шинэчлэгдэж байх шаардлагатай байна.

Глоб Интернэшнл төв ТББ-тай хамтран олон улсын шинжтэй хэд хэдэн хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, хүний нэр төр, хувийн нууцыг хамгаалах талаар хийгдсэн судалгааны үр дүнг танилцуулах, интернет засаглал, шүгэлдэгчийн зохицуулалт зэрэг сэдвээр асуудал дэвшүүлэн хэлэлцүүлээ.



Глоб Интернэшнл төв ТББ-тай хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг, арга хэмжээний үеийн зургуудаас харуулав. 2015 он. Гэрэл зургийг Э. Сайнтүвшин

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Нээлттэй нийгэм сангуудын санхүүжилтээр 2014 оноос эхлэн Дэлхийн нөөцийн хүрээлэн олон улсын байгууллагын арга зүйн дэмжлэгтэйгээр иргэд оршин суугаа нутаг орныхоо байгаль орчны байдал, усны нөөц, бохирдлын хүчин зүйл зэрэг мэдээллийг авч улмаар өөрсдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ баталгаажуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой төсөл Индонез болон Монгол улсуудад хэрэгжиж байгаа билээ. Үг төслийн Монгол дахь зохицуулагчаар ННФ ажиллаж байна.

Төслийн эхний шат 2015 оны 6 сар хүртэл үргэлжлэн усны талаарх мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн судалгаа хийх, иргэдийн оролцооны загвар төсөл хэрэгжүүлэх, байгаль орчны мэдээллийг нийтэд ил болгох загвар стандарт боловсруулах зэрэг чиглэлд Хүний эрх, хөгжил төв, Хөвсгөл далайн эзэд, Ил тод байдал сан, Байгаль орчин, эрүүл мэнд төв зэрэг ТББ-уудтай хамтран ажилласан юм. Төслийн эхний шатны ажлыг дүгнэн дараагийнхыг төлөвлөх зорилгоор 2015 оны 6 сарын 22-24-нд Улаанбаатар хотноо Дэлхийн нөөцийн хүрээлэнгээс оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Монгол Улс болон Индонез Улсын төслийн багийнхан, орон нутгийн байгаль орчны албаны төлөөлөл оролцлоо. Хэлэлцүүлгийн хүрээнд БОНХАЖЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, Хан-Уул дүүргийн 13-р хороонд Туул голын нөхцөл байдалтай газар дээр нь танилцан нутгийн иргэдийн төлөөлөлтэй уулзан санал солилцов.



Дээд эгнээнд: ХУД-ийн 13-р хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй байдал  
Доод эгнээнд зүүн гар талаас: Хэлэлцүүлгийн явц, дараагийн хоёр зурагт нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын явц  
2015 он. Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл

Дээрх хэлэлцүүлгийн дараа Нээлттэй нийгэм сан Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах төслийг үргэлжлүүлэн дэмжих шийдвэр гаргаж 2015 оны 10 дугаар сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд дараах иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахаар тэтгэлэг олгож, үйл ажиллагааг эхлүүлээд байна. Үүнд:

### БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД ТӨВ

- Уул уурхай, үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжийн хаягдал, бохирдуулах бодисын нэр төрөл, хэмжээг олон нийтэд мэдээлэх үүднээс суурь судалгаа хийх
- Усны засаглалын талаар харьцуулсан судалгаа хийх
- Аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа талаар, тэр дундаа байгаль орчны нөлөөллийн талаар олон нийтэд өгч байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж судлах, улмаар БОНХАЖЯ-д бодлогын Зөвлөмж боловсруулж хүргүүлэх;

### ИЛ ТОД БАЙДАЛ САН

- Аймаг, сум, баг болон нийслэлийн захын дүүрэг хороодын иргэд, оршин суугчдад байгаль орчны мэдээллийг ил тод, нээлттэй болгох арга зүй, аргачлалын баримт бичиг боловсруулах
- Мэдээллийг бодитой харуулах цахим мэдээллийн сан, вэб хуудас бий болгож тухайн орон нутгийн иргэдэд ашиглах боломжийг бүрдүүлэх
- Төслийн үр дүнг иргэд болон сонирхогч талуудад сонирхолтой, ойлгомжтой хэлбэрээр хүргэх;

### ХӨВСГӨЛ ДАЛАЙН ЭЗЭД ХӨДӨЛГӨӨН

- Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор усны мониторинг хийх замаар оршин суугаа орон нутгийнхаа байгалийн нөөц ашиглалтын талаар тэднийг мэдээлэлтэй болгох, мөн шийдвэр гаргах явцад оролцох, нөлөөлөл хийх чадавхыг нь нэмэгдүүлэх
- Олон нийтэд цэвэр усаар хангагдах эрх, тэр дундаа усны чанар, бохирдлын талаар мэдээлэл авах эрхийг таниулан сурталчлах чиглэлээр залуучууд, сэтгүүлчидтэй хамтран ажиллана.


### STRIPE ТӨСЛИЙН ЭХНИЙ ШАТНЫ ҮР ДҮН

- Байгаль орчны ардчиллын индекс аргачлалын дагуу байгаль орчны мэдээллийн ил тод байдлыг үнэлэн БОНХАЖЯ-ны дэргэдэх мэдээллийн санд иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл байгаа эсэхэд мониторинг хийв. Эдгээр шинжилгээ, судалгаанд үндэслэн төрийн болон төрийн бус байгууллага, шинжээчдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж байгаль орчны мэдээллийн загвар стандарт болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Үг баримт бичгийг батлуулснаар иргэд амьдарч буй орчныхоо талаарх хэрэгцээт мэдээллийг баг, хорооныхоо төвшинд авах боломж бүрдэх юм.
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу ХУД - ийн 13-р хороо, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэдийн төлөөлөл төслийг хэрэгжүүлэгч иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр орон нутагт нь эрхэлж буй уул уурхайн үйл ажиллагааны талаар төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх туршилтын төсөл хэрэгжүүлээ. Үр дүнд нь хуулийн талаарх иргэдийн ойлголт мэдээлэл нэмэгдэхийн хамт хуулийн хэрэгжилтийг хангахад учирч буй бэрхшээлийг олж мэдсэнээрээ онцгой ач холбогдолтой байв.
- Иргэд сайн дураараа нэгдэн амьдралдаа тулгамдаж буй асуудлыг өргөн хүрээнд хэлэлцэж, хамтдаа шийдэл эрэлхийлэх чадавхтай болж байгаа нь төслийн нэг гол үр дүн юм. ХУД - ийн 13-р хорооны иргэд хамтран “Шинэ суурьшил, эрүүл аюулгүй орчин” хэмээх шинэ ТББ байгуулан төрийн байгууллага болон ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгжид хандан нөлөөлөл хийх замаар иргэдийн эрх ашгийн үүднээс үйл ажиллагаа явуулж эхлээд байна (Товч түүхийг дараах хуудасны зурган өгүүлэмжээс харна уу).



## Цэцэгээгийн түүх

(ЭРҮҮА АЮУЛАГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХЭЭ ХАЙСАН НЬ)



## ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ

2006 онд батлагдсан Авлигын эсрэг хуулиас хойш төрийн ил тод байдал, хариуцлагын механизмыг зохицуулах эрх зүйн орчинд томоохон дэвшил гарсан нь 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, түүнчлэн 2012 оноос эхлэн хэрэгжиж буй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль юм. Дээрх хуулиуд батлагдан хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хэрэгжилт нь ямар түвшинд байгаа талаар бодит мэдээлэл, судалгаа шинжилгээг шийдвэр гаргагчид болон олон нийтэд хүргэх, цаашид хэрэгжилтийг сайжруулах зорилгын хүрээнд ННФ судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж ирлээ.

2015 онд ННФ-ын “Төрийн бус байгууллагын мониторинг” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Сонгогчдын Боловсрол Төв “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйл буюу “Хандив авахтай холбогдсон хязгаарлалт”-ын хэрэгжилтэд мониторинг хийв. Дээрхээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт орон нутагт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх зорилгоор Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн Өвөрхангай аймаг дахь салбар, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Төв аймаг дахь салбаруудад тус тус дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

### МОНИТОРИНГИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ



Мониторингийн тайланд төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүлээн авч буй хандив, санхүүгийн туслалцаа нь сайн дурын байх ёстой атал албадлагын шинжтэй болсныг, тэрчлэн хандив авахаар хүсэлт гаргах хориотой байтал өөрсдөө хандивлагчдад хандан гуйх, хүсэлт гаргаж хандив цуглуулдаг олон арга хэлбэр түгээмэл байгааг онцолсон байна. Түүгээр ч зогсохгүй хуулиар хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагууд хандив хүлээн авснаас хойш хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглодог байтал бодит байдалд хандивлагчид зориулан шийдвэр гаргадаг тохиолдол түгээмэл байгааг мөн тодорхой баримттайгаар дурдсан байна.

Дээрх байгууллагууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2-р бүлгийн 7, 8, 9-р зүйл буюу

- албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй бол түүнийг хэрхэн мэдэгдэж зохицуулах;
- бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөлөл ирсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар зохицуулалтууд хэрхэн хэрэгжиж байгаад мониторинг хийж үр дүнг олон нийтэд танилцуулав.

Түүнчлэн Хөвсгөл аймагт Төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн засаг даргын 2013 онд гаргасан захирамжийн хэрэгжилтэд мониторинг хийхэд нь Хөвсгөл далай ээж нийгэмлэгт дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн дээрх мониторингоос гадна авлигаас урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд “Төрийн дунд шатны албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл явц, журам, өнөөгийн байдал” сэдэвт бодлогын судалгааг МУИС-ийн Социологи, Нийгмийн ажилтны тэнхимийн багш М.Батбаатар хийж гүйцэтгэв. Судлаач татварын мэдээлэл, хөрөнгө санхүүгийн бүртгэл төгөлдөршөөгүй өнөөгийн нөхцөлд Авлигатай тэмцэх газраас төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүрэн гүйцэд хянах боломж хомс, хөрөнгө орлогын мэдүүлэгт төлөвлөгөөт хяналт хийхдээ магадлалын арга ашиглахгүй байгааг шүүмжлээд цаашид хяналт шалгалтыг үр дүнтэй болгохын тулд хяналт хийх мэдүүлгийг санамсаргүй сонголтоор тооцоолох аргачлал боловсруулах нь чухал болохыг онцолжээ.

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

- **ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ**
- **ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО**
- **ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА БИЗНЕСИЙН ОРЧИН**
- **ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ**

## ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ

Улс орны эдийн засгийн тулгуур салбар болох эрдэс баялгийн салбарт ил тод, нээлттэй байдал, хариуцлагыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллах нь ННФ-ын стратегийн үндсэн зорилтуудын нэг юм. Бид эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг бэхжүүлэх нэг гол хэрэгсэл нь Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС) гэж үзэн, түүний хэрэгжилтийг дэмжих чиглэлээр 2006 оноос өнөөг хүртэл тогтвортой ажилласны үр дүнд тодорхой ахиц дэвшил гарлаа. ННФ нь ОУИТБС-ын хэрэгжилтийг Монгол Улсад зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнээр ажиллахаас гадна санаачилгын үйл явц дахь иргэний нийгмийн оролцооны үр нөлөөг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллаж ирлээ. Олборлох салбарт засаглалын асуудлаар үр нөлөөтэй ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр “Төлсөн авсанаа нийтэл” иргэний нийгмийн эвсэл (ТАН эвсэл)-тэй нягт хамтран ажилладаг бөгөөд 2015 оноос тус эвслийн зохицуулагчаар сонгогдон ажиллаж байна.

2015 он нь олон улсын болон үндэсний хэмжээнд ОУИТБС-тай холбоотой олон чухал үйл явдал өрнөсөн, санаачилгын хэрэгжилт, үр нөлөөг үнэлж дүгнэн, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход шийдвэрлэх жил байлаа. Тухайлбал, Монгол Улс ОУИТБС-ын “туршилт”-ын баталгаажуулалтад орж, уг Санаачилгын стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаа олон улсын хэмжээнд үнэлүүлээ. ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс баталгаажуулалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний аргачлалыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монгол Улс ийнхүү “туршилт”-ын буюу шинэ аргачлалын дагуу баталгаажуулалтад хамрагдсан юм. Хэдийгээр энэхүү баталгаажуулалтын дүн нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орны хувьд Монгол Улсын статуст ямар нэг байдлаар нөлөөлөхгүй боловч уг Санаачилгыг хэрэгжүүлж ирсэн үйл явц, түүний үр нөлөөг олон улсын шинжээчдээр үнэлүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ байв. Учир нь “туршилт”-ын баталгаажуулалтаар салбарын засаглал, ил тод байдлыг сайжруулахад анхаарах асуудлуудыг тодорхойлж, зөвлөмж өгсөн нь ОУИТБС-ын хэрэгжилт, үр нөлөөг хангах, 2016 онд явагдах “жинхэнэ” баталгаажуулалтад бэлтгэхэд ач холбогдолтой юм. Монгол Улс 2015 онд олборлох салбарт ил тод байдлыг хэрхэн хангаж байгаагаа ийнхүү олон улсад үнэлүүлснээс гадна ОУИТБС-ын Үндэсний анхдугаар чуулган зохион байгуулж алдаа оноо, сургамж бэрхшээлээ улсын хэмжээнд үнэлэн цаашид авах арга хэмжээгээ тодорхойллоо.

ОУИТБС-ын 2014 оны тайлан нь бичил уурхай эрхлэгчдийн болон байгаль орчныг нөхөн сэргээх гэрээний мэдээлэл зэрэг өмнөх тайлангуудад огт багтдаггүй байсан шинэлэг мэдээлэл агуулснаас гадна нэгтгэл тайланд орох компаниудыг “эрсдэлд суурилсан” аргачлалаар сонгосон нь онцлог

**ОУИТБС-ын 9 дэх удаагийн  
Үндэсний нэгтгэл тайланг анх удаа  
цахим системд тулгуурлан шинэлэг  
аргачлалаар бэлтгэн гаргалаа.**

VIP76.MN САЙТ ДЭЭР ЯВАГДСАН  
ОНЛАЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦ  
/2015 оны 10 сар/



байлаа. Ингэснээр улсын түвшинд өндөр хэмжээтэй төлбөр, орлого бүрдүүлсэн томоохон компаниудаас гадна орон нутгийн хэмжээнд “материаллаг” гэж тооцогдох төлбөр, орлого бүрдүүлсэн жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл анх удаа үндэсний нэгтгэл тайланд тусгагдсан юм. Гэхдээ тайлан гаргагч компанийн тоо өмнөх жилүүдээс эрс буурч нийт 1,557 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн 62 хувь буюу 980 компани л ил тод байдлын тайлан гаргасан нь цахим тайлагналын системийг 2014 онд анх удаа хэрэглэсэнтэй холбоотой байв. Түүнчлэн үндэсний нэгтгэл тайлангаар 531 сая төгрөгийн тайлбарлагдаагүй зөрүү илэрсэн нь ОУИТБС-ын хэрэгжилтийг хуульчилж, компани болон засгийн газар хоорондын төлбөр, орлогын зөрүүг нарийвчлан шалгах талаар төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байгааг илтгэн харуулж байна.

### ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ННФ-ын Засаглалын хөтөлбөрөөс 2015 онд эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэрээний ил тод байдлыг хангах, иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх замаар төв, орон нутагт төрийн үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалыг сайжруулах зэрэг зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дэмжин ажиллалаа. Энэ хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг өрнүүлж, ТАН эвслийн гишүүдээс бүрдсэн хуулийн нөлөөллийн ажлын хэсэг байгууллаа. Тус Ажлын хэсэг хуулийн төслийг ОУИТБС-ын стандарттай харьцуулан үнэлж, иргэний нийгмийн санал шүүмжийг боловсруулан холбогдох талуудад хүргүүлсэн юм (санал шүүмжийг www.forum.mn сайтаас үзнэ үү). Энэхүү хуулийн төсөл нь 2014 онд УИХ-д өргөн баригдсанаас хойш өнөөг хүртэл батлагдахгүй хүлээгдсээр байгаа юм. Иймд ТАН эвслийн Ажлын хэсэг уг хуулийн төслийг дэмжих зорилгоор VIP76 сэтгүүлээр дамжуулан салбарын мэргэжилтнүүдийг оролцуулсан цахим хэлэлцүүлэг өрнүүлж, УИХ-ын гишүүдтэй уулзалт ярилцлага хийлээ.

Мөн энэ чиглэлээр ОУИТБС-ын ач холбогдол, түүнийг хуульчлах хэрэгцээ шаардлагыг илтгэн харуулсан шторк бэлтгэн МҮОНТ-ээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Үүний үр дүнд хуулийн төслийг УИХ-ын чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх ажил эрчимжиж, Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Дэд ажлын хэсэг байгуулагдав. Тус Дэд ажлын хэсэгт ННФ болон ТАН эвслийн гишүүд орж ажилласнаар хуулийн төсөлд саналаа тусгуулж чадлаа. Ялангуяа, ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц тогтолцоо, гэрээний болон ашиг хүртэгч эздийн ил тод байдал, тайлангаар илэрсэн зөрүүг хянан шалгах талаарх төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг хуульчлахтай холбоотой заалтууд хуулийн төсөлд тусгалаа оллоо. Гэсэн ч хуулийн төсөл өнөөг хүртэл хүлээгдсээр байгаа төдийгүй УИХ-ын зарим гишүүдийн санаачилгаар ил тод байдлын санаачилга дахь иргэний нийгмийн оролцоог хязгаарлахад чиглэсэн зарим нэг заалт тусгагдсан нь иргэний нийгмийн хүрээнд болгоомжлол төрүүлээд байна.

### ЭРДЭС БАЯЛГИЙН ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, МОНИТОРИНГ

ННФ нь 2014 оноос Монгол Улсад эрдэс баялгийн гэрээний ил тод байдлыг хангах үйл явцыг санаачлан тодорхой үр дүнд хүрээд байна. Монгол Улсын Засгийн газраас 2015 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг шинэчлэн батлахдаа “нууцлал”-ын заалтуудыг хассан нь газрын тосны салбарт гэрээний ил тод байдлыг хангах эхлэлийг тавилаа. Түүнчлэн Уул уурхайн яамны дэргэд Эрдэс баялгийн гэрээний ил тод байдлыг хангах Ажлын хэсэг байгуулагдан энэ чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх, гэрээний мэдээллийн цахим сан байгуулах зорилт тавин ажиллаж байна. ННФ уг Ажлын хэсгийн гишүүний хувиар гэрээний ил тод байдлын эрх зүйн орчны талаар бодлогын судалгаа хийж, мэдээллийн санг байгуулах ажлыг хариуцан ажиллаж байна. 2016 онд ашиглалтад орох дээрх мэдээллийн санд Засгийн газраас хөрөнгө оруулагч нартай байгуулсан Хөрөнгө оруулалтын болон Бүтээгдэхүүн хуваах зэрэг томоохон гэрээнүүд төдийгүй орон нутагт уул уурхайн салбарт байгуулагдаж байгаа Газар ашиглах, Ус ашиглах, Орон нутаг хөгжүүлэх зэрэг бүх гэрээг байршуулж, олон нийтэд хүргэх юм.

Төрөөс ашигт малтмалын томоохон ордуудыг эргэлтэд оруулах замаар эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх бодлого баримталж байгаа энэ цаг үед гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хийгдэж байгаа гэрээ хэлэлцээрт

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗЭЭР ЦАЦАГДСАН ОУИТБС - ЫН ТАЛААРХ ШТОРКИЙН ГОЛ МЭДЭЭЛЭЛ /2015 ОНЫ 12 САР./



### ЭРДЭС БАЯЛГИЙН АСУДЛААР ГАРГАСАН ХЭВЛЭН НИЙТЛЭЛ



нийтийн ашиг сонирхлын үүднээс хөндлөнгийн хяналт, дүн шинжилгээ хийх шаардлага чухлаар тавигдаж байна. Энэ хүрээнд эрдэс баялгийн салбарын гэрээнд дүн шинжилгээ, мониторинг хийх иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй (ББЗХ)-тэй хамтран “Олборлох салбарын гэрээнд дүн шинжилгээ, мониторинг” хийх нь сэдэвт 3 өдрийн сургалт зохион байгуулж, энэ чиглэлээр ажилладаг 30 гаруй төрийн бус байгууллагыг хамрууллаа. Түүнчлэн, ББЗХ-ийн шинжээч мэргэжилтнүүдийн боловсруулсан “Уул уурхайн гэрээг хэрхэн уншиж, ойлгох вэ?” сэдэвт гарын авлага монгол хэлнээ хөрвүүлэгдэж байна. Сургалтад оролцогчид Хөрөнгө оруулалтын болон бүтээгдэхүүн хуваах зэрэг олон асуудлыг хамарсан томоохон гэрээнүүд төдийгүй орон нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулдаг Хамтын ажиллагааны гэрээний санхүүгийн болон нийгэм, байгаль орчны үүрэгт мониторинг хийх арга зүйг эзэмшлээ. Мөн сургалтад оролцсон төрийн бус байгууллагуудын гэрээний мониторингийн үйл ажиллагааг дэмжих тэтгэлэг олгон ажиллаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн захиргаатай байгуулдаг Орон нутаг хөгжүүлэх гэрээний загварыг боловсруулах үйл явц 2015 онд өрнөлөө. ННФ орон нутгийн гэрээ байгуулахад нутгийн иргэдийн оролцоог хангах, гэрээний хэрэгжилт үр нөлөөг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, Уул уурхайн яам болон холбогдох талуудад хүргүүлээ (Судалгааны дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.). Мөн ТАН эвсэлтэй хамтран орон нутгийн гэрээнд ил тод байдлыг хангах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хянах үйл явц дахь иргэдийн оролцоог баталгаажуулахтай холбоотой санал боловсруулж нөлөөлөл хийсэн нь амжилттай боллоо. Үр дүнд нь 2016 оны 3 дугаар сард батлагдсан “гэрээний загвар”-т иргэдийн тэгш төлөөлөл бүхий Хамтын ажиллагааны хороо байгуулах замаар олон нийтийн оролцоог хангах, гэрээг нийтлэх, иргэдэд тогтмол мэдээлэл хүргэх талаарх гэрээний талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон заалтууд тусгагдлаа. 2017 оноос хэрэглэгдэж эхлэх энэхүү шинэлэг зохицуулалтын бодит хэрэгжилтийг хангахад цаашид анхаарч ажиллах юм (Засгийн газрын 2016 оны 3 сарын 18-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Загвар гэрээ”-г бүрэн эхээр нь Уул уурхайн яамны [www.mn.gov.mn](http://www.mn.gov.mn) сайтаас үзнэ үү.). Түүнчлэн, 2015 онд эрдэс баялгийн салбарт гарсан нэг томоохон үйл явдал бол төрөөс Таван толгойн нүүрсний ордыг ашиглах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр хийсэн явдал байлаа.

Энэхүү хэлэлцээрийн явцад ННФ нь гэрээний төсөлд иргэний нийгмийн зүгээс дүн шинжилгээ хийж санал, зөвлөмж боловсруулан холбогдох талуудад хүргэлээ (Дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас

үзнэ үү.). Эрдэс баялгийн салбарын гэрээнд дүн шинжилгээ хийх чиглэлээр ТАН эвслийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор эвслийн гишүүдээс бүрдэх Ажлын хэсэг байгуулж дэмжиж ажиллалаа. Дээрх ажлын хэсэг нь салбарын холбогдох мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар Таван толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд дүн шинжилгээ хийж, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

#### ОУИТБС - ЫН ХЭРЭГЖИЛТ

2015 онд ОУИТБС-ын хэрэгжилтийг дэмжих чиглэлээр ББЗХ, Санаачилгын Ажлын алба, ТАН эвсэл зэрэг талуудтай хамтран үр нөлөөтэй ажиллалаа. ББЗХ-тэй хамтран ОУИТБС-ын мэдээллийн санг ашиглах, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, энгийн ойлгомжтой байдлаар боловсруулан иргэдэд хүргэх чиглэлээр хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан 3 өдрийн сургалт зохион байгуулав. Түүнчлэн, ОУИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 6 аймагт ОУИТБС-ын Дэд зөвлөлийг бэхжүүлэх сургалт, олон талт хэлэлцүүлэг зэрэг цогц үйл ажиллагаа явууллаа. Энэхүү үйл ажиллагааг орон нутгийн төрийн бус байгууллагуудын чадавх, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлснээр Ховд, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Дундговь аймгуудад эрдэс баялгийн асуудлаар мэргэшин ажиллах төрийн бус байгууллагууд бий боллоо. Энэ үйл ажиллагааны үр дүнд Ховд, Өмнөговь, Дорнод, Дундговь аймгийн ОУИТБС-ын Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумд, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт иргэний нийгмийн тэнцүү төлөөлөл бүхий ОУИТБС-ын салбар зөвлөлийг шинээр байгууллаа.

ББЗХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн уг үйл ажиллагааны хүрээнд дээрх 6 аймаг, нийслэлийн 1 дүүрэгт зохион байгуулагдсан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, хариуцлагын асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлэгт нийтдээ 378 иргэн оролцож мэдээлэл авсан байна. Мөн ОУИТБС-ын Үндэсний анхдугаар чуулганыг зохион байгуулахад идэвхтэй оролцлоо. 2015 оны 11 дүгээр сарын 3-4-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Үндэсний чуулганд төв орон нутгийн төр, иргэний нийгмийн байгууллагын 250 төлөөлөгч оролцож, ОУИТБС-ын

хэрэгжилт, үр нөлөөг үнэлэн тулгарч буй бэрхшээл сорилт, шийдвэрлэх арга замыг хэлэлцэн Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн үндсэн чиглэлийг тодорхойллоо. ННФ нь Үндэсний Чуулганд орон нутгийн оролцоог хангахад анхаарч, дэмжлэг үзүүлэн ажилласнаар чуулганд 13 аймаг, 11 сумаас 68 төлөөлөгч ирж оролцсон нь орон нутагт тулгарч байгаа бэрхшээл сорилтыг үндэсний хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэх боломжийг нээж өгсөн юм.

ОУИТБС-ын хүрээнд уул уурхай, газрын тосны салбарт үйл ажиллагаа

ННФ нь үндэсний чуулганы зорилго, агуулгыг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэж, ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, ялангуяа иргэний нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр Үндэсний чуулганд асуудал дэвшүүлэн хэлэлцүүлсэн нь уг чуулганы Зөвлөмжид орж, улмаар ОУИТБС-ын дунд хугацааны стратегийн баримт бичигт тусгагдлаа.

явуулж буй компаниуд улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хандив тусламжаа жил бүр нээлттэй зарлаж, үүнийг нь Засгийн газрын хүлээн авсан орлоготой харьцуулж үзэх болсноор өмнө нь тодорхойгүй, эсвэл хаалттай байсан олон мэдээлэл ил тод болж байна. Гэсэн хэдий ч дээрх тайлангийн тоо баримтыг олон нийтэд ойлгомжтой илэрхийлж, хялбаршуулан тайлбарлах, макро эдийн засгийн болон орон нутгийн мэдээлэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, салбарын бодлого шинэчлэлтэд ашиглах нь тайлан гаргахаас дутуугүй ач холбогдолтой билээ. Иймээс ННФ ОУИТБС-ын 2011-2013 оны тайлангуудад дүн шинжилгээ хийж үр дүнг нь “Өгөгдлийн уурхай-2” товхимлоор олон нийтэд хүргэлээ. “Өгөгдлийн уурхай 1”-ийг ТАН эвсэлтэй хамтран 2013 онд гаргаж байсан билээ (Товхимлыг бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.).



Дээд эгнээнд: ОУИТБС-ын Үндэсний анхдугаар чуулганд Ил тод сан ТББ-ын захирал Д.Цэрэнжав илтгэл тавьж байгаа нь

Доод эгнээний баруун гар талаас: Хил хязгааргүй алхам ТББ-ын захирал Б.Баярсайхан, Үндэсний чуулганд оролцсон иргэний нийгмийн төлөөлөгчид, Монголын ОУИТБС-ын зохицуулагч Ш.Цолмон, ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Ажлын хэсгийн ахлагч Б.Дэлгэрмаа нар. 2015 оны 11 дүгээр сарын 3-4, Улаанбаатар хот.

Уул уурхайн салбарт хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зорилгоор нийтийн эрх ашгийн өмгөөллийн тэтгэлэгт хөтөлбөр зарлаж, 2 төрийн бус байгууллагад арга зүй болон санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд байгаль орчинд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс нэхэмжлэн гаргуулах үүрэгт ажлаа зохих ёсоор хэрэгжүүлэхгүй байгаа БОНХАЖЯ, тэрчлэн уул уурхайн компанийн хууль бус үйлдлийг зогсоолгох зүй ёсны шаардлага гаргасан орон нутгийн иргэдийн эсрэг үндэслэлгүйгээр удаа дараа эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан прокурорын байгууллагын тодорхой албан тушаалтанд хариуцлага тооцуулах нэхэмжлэлийг захиргааны болон иргэний шүүхэд гаргаад байна. Түүнчлэн нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалахад тулгарч буй гол бэрхшээл болох нэхэмжлэх эрхийн асуудлаар “Далай юу, фосфорит уу?” баримтат нэвтрүүлгийг Хөвсгөл далайн орчимд олгогдсон фосфоритын тусгай зөвшөөрлийг цуцлуулах стратегийн өмгөөллийн хэрэгт тулгуурлан бэлтгэж олон нийтэд хүргэлээ (Нэвтрүүлгийг [www.fogum.mn](http://www.fogum.mn) сайтаас үзнэ үү.).

Эрдэс баялгийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитойгоор үнэлж дүгнэхэд тухайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт, борлуулалтын дүн мэдээ чухал ач холбогдолтой билээ. Дээрх мэдээллийг ОУИТБС болон Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэл, статистикийн газар зэрэг төрийн хэд хэдэн байгууллага хариуцан гаргаж байгаа ч тэдгээр нь бүгд хоорондоо зөрүүтэй байдаг байна. Иймд дээрх тайлан мэдээнд зөрүү гарч байгаа үндсэн шалтгааныг тогтоож арилгах арга замыг санал болгох судалгааг санаачлан эхлүүлээд байна.

#### ТАН ЭВСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ННФ нь ТАН эвслийн зохицуулагчийн хувьд “Төлсөн авсанаа нийтэл” олон улсын иргэний нийгмийн сүлжээний Евро-Азийн бүсийн чуулга уулзалт болон чадавч бэхжүүлэх сургалт семинарыг 2015 оны 11 дүгээр сарын 4-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Бүсийн чуулга уулзалтад Казахстан, Киргизстан, Азербайжан, Тажикстан, Албани, Гүрж, Украин улсуудын төрийн бус байгууллагын ажилтнууд болон Төлснөө нийтэл сүлжээний Олон улсын нарийн бичгийн

дарга нарын газрын холбогдох ажилтнууд зэрэг гадаадын нийт 19 төлөөлөгч оролцсоноос гадна ТАН эвслийн 10 гаруй гишүүд оролцлоо. Чуулга уулзалтаар эрдэс баялгийн засаглалын асуудлаар ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад тулгамдаж буй нийтлэг асуудал, хамтын шийдэл гарцын талаар зөвлөлдлөө. Энэхүү арга хэмжээг ОУИТБС-ын Үндэсний чуулгантай уялдуулан зохион байгуулсан нь олон улсын төлөөлөгчдөд Монгол Улс дахь ил тод байдлын санаачилгын хэрэгжилт, түүнд

ОУИТБС-ын Үндэсний чуулганы үеэр “Төлсөн авсанаа нийтэл” олон улсын иргэний нийгмийн сүлжээний Евро-Азийн бүсийн чуулга уулзалт хийж олон улсын төлөөлөгчдөд Монгол дахь Санаачилгын хэрэгжилт, тулгарч буй асуудалтай танилцсанаас гадна харилцан туршлага солилцох боломж бүрдсэн юм.

тулгарч буй асуудалтай гүн гүнзгий танилцах боломж олгосноос гадна дээрх улсуудын туршлагаас суралцах боломжийг Үндэсний чуулганы оролцогчдод олгосон юм.

#### ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Мөн 2015 онд олборлох салбарын засаглалыг бэхжүүлэх хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага сургамж хуваалцах талаар тодорхой ажлууд хийлээ. Казахстан Улсын Нээлттэй Нийгэм Хүрээлэнтэй хамтран ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх, төсвийн төвлөрлийг бууруулах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангах чиглэлээр туршлага судлах аяллыг Монгол Улсад зохион байгууллаа. Казахстан Улсын төрийн болон төрийн бус байгууллагын 10 гаруй төлөөлөгч оролцсон уг туршлага судлах аяллаар төлөөлөгчид Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтэций суманд ажиллаж, ил тод байдлын санаачилгыг орон нутагт хэрэгжүүлж байгаа Монгол Улсын туршлагатай танилцлаа. Түүнчлэн, уг аяллын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран “Төсвийн төвлөрлийг сааруулах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангах нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.



“Төлсөн авсанаа нийтэл” олон улсын иргэний нийгмийн сүлжээний Евро-Азийн бүсийн чуулга уулзалт, Улаанбаатар хот, 2015 оны 12 сарын 16.  
Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл

## ШИЛЭН ДАНСНЫ МОНИТОРИНГИЙН ДҮН



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мониторингод бүх аймаг, аймгийн төвийн сумд, нийслэл, дүүргийн нийт 52 Засаг даргын тамгын газар хамрагдав. Дүнг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.

### ШИЛЭН ДАНСНЫ МОНИТОРИНГОД ХАМРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ (Шилэн дансны хуулийн 6.4.4 дэх заалт)
- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрийн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр (Шилэн дансны хуулийн 6.4.5 дахь заалт)
- Шилэн дансны 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрт холбогдох шийдвэр (Шилэн дансны хуулийн 6.10 дахь заалт)
- Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (Шилэн дансны хуулийн 6.1.2 дахь заалт)
- 10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гэрээний дүн, зарлагын мэдээлэл (Шилэн дансны хуулийн 6.9 дэх заалт)

## ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Монгол Улсын төсвийн удирдлага, өрийн асуудал иргэдийн анхаарлын төвд орж нийгэмд энэ талаар цөөнгүй хэлэлцүүлэг өрнөж байна. Нөгөө талаас, төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн эрх мэдэл, зарцуулах хөрөнгийн хэмжээ нэлээд нэмэгдэж байгаа билээ. Иймд татвар төлөгчдөөс хуримтлуулсан хөрөнгийг үр ашигтай зарцуулах, улмаар иргэдэд хүртээмжтэй өсөлт бий болгоход төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах нь хойшлуулшгүй чухал асуудал юм. Монгол Улсад төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах хууль эрхзүйн орчинд зарим дэвшил гарч байна. Тухайлбал, Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн нь төсвийг ил тод болгоход дорвитой өөрчлөлт авчрах ач холбогдолтой үйл явцын эхлэл болов.

ННФ төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад тогтмол анхаарч ирсэн бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэх, төсвийн удирдлагад хяналт тавих, иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагааг байнга дэмжин ажиллаж ирлээ. Тухайлбал, төсвийн зарцуулалтад мониторинг хийхэд нь ТББ-уудад дэмжлэг үзүүлэн хууль эрх зүйн орчныг шинэчлэхэд иргэний нийгмийн дуу хоолойг тусгахад анхаарч, төсвийн ил тод байдлыг хангах хууль эрхзүйн орчинд нааштай өөрчлөлт гарахад зохих хувь нэмэр орууллаа. Бид 2015 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөл үзүүлэх зорилгоор уг хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт, мониторинг хийсэн ба улсын төсвийн ил тод байдалд үнэлгээ хийж дүнг олон нийтэд танилцууллаа. Түүнчлэн, улсын болон орон нутгийн төсвийн үйл явцыг мэдээлэх цахим цаглабар боловсруулан тогтмол ажиллагааг нь хангаж ирлээ.

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, МОНИТОРИНГ

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран 2015 оны эхний хагас жилд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрхэн хангаж байгаад хийсэн мониторингод Монгол Улсын бүх аймаг, аймгийн төвийн сумд, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газруудыг хамруулж, хуулийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөх үйл ажиллагаа явууллаа. Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд ил тод болговол зохих нийт 28 төрлийн мэдээллээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, тэдгээрт холбогдох шийдвэрт хяналт тавилаа. Тэрчлэн

**Мониторингийн дүнг [www.forum.mn](http://www.forum.mn) сайт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэж, 2015 оны 5 сард ЕТГ, Үндэсний аудитын газар, Сангийн яам, ННФ хамтран зохион байгуулсан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” хэлэлцүүлгийн үеэр танилцуулав.**

төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон 10 сая төгрөгөөс дээших худалдан авалтын төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх мэдээллийн ил тод байдалд хяналт мониторинг хийв.

Өргөн хүрээнд хийсэн энэхүү мониторингийн үйл ажиллагаа нь орон нутагт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зохих нөлөө үзүүлж, 2015 оны хоёрдугаар улиралд төсвийн мэдээллийн ил тод байдал нэмэгдсэн нь мониторингийн дүнгээс харагдав.

### ТӨВ ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН СУДАЛГАА

Дэлхийн 100 гаруй улс орны засгийн газар төсөв, санхүүгийн мэдээллээ олон нийтэд хэр нээлттэй болгож байгааг үнэлдэг “Төсвийн нээлттэй байдлын судалгаа”-нд Монгол Улс 2006 оноос хамрагдаж ирсэн бөгөөд 2015 онд 5 дахь удаагаа оролцлоо. Улсын төсвийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор уг шинжилгээг АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл байгууллага ([www.internationalbudget.org](http://www.internationalbudget.org))-ын аргачлалын дагуу ННФ-ын судлаачид гүйцэтгэдэг болно. Энэхүү судалгаагаар төв засгийн газрууд төсвийн холбогдолтой найман гол баримт бичгийг олон нийтэд тайлагнасан байдал, мөн эдгээр баримт бичигт орсон мэдээллийн иж бүрэн, шуурхай, ашиглаж болохуйц байдалд үнэлгээ өгдөг юм. Судалгаанд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Олон улсын аудитын дээд байгууллага зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын боловсруулсан шалгуур үзүүлэлтийг ашиглаж, нэгдсэн индекс гаргадаг.

“Төсвийн нээлттэй байдал - 2015” судалгаагаар манай улсын Засгийн газар нийт авбал зохих 100 онооноос 51 авсан нь төсвөө нээлттэй, ил тод болгох чиглэлээр ихээхэн ажиллах шаардлагатай байгааг харуулав. Энэхүү судалгаа 2 жил тутамд явагддаг ба дүнг олон улсын донор болон судалгааны байгууллагууд өргөн ашигладаг юм. Монгол Улсын төсвийн ил тод

байдлыг сайжруулахад нөлөөлөл үзүүлэх зорилгоор судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд таниулах, төр засгийн холбогдох яам, газруудад хүргэх зэрэг үйл ажиллагаа явууллаа.

Төсвийн нээлттэй байдлын энэхүү судалгаа нь Монгол Улсын төв засгийн газрын төсвийн нээлттэй байдлын түвшинг тодорхойлж, бусад улс оронтой харьцуулах боломж олгодгоороо ач холбогдолтой юм. Судалгааны хүрээнд Олон улсын төсвийн түншлэл байгууллага болон ННФ хамтран манай улсын төсвийн нээлттэй байдлыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргав. Эдгээрээс дурдвал:

1. Төсвийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр:

- Гүйцэтгэх засаглалын төсвийн төслийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (Зарлагыг чиг үүргийн ангиллаар, макро эдийн засгийн таамаглалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэх).
- Төсвийн хагас жилийн тоймыг нийтэд мэдээлэх (Хагас жилийн тойм нь эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл агуулахаас гадна сүүлийн хагас жилийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, эдийн засгийн байдлын талаарх таамаглалын мэдээлэл агуулдгаараа нийтэд ач холбогдолтой юм).
- Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (Төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх).

2. Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоог сайжруулах чиглэлээр:

- Хууль тогтоох байгууллагын зүгээс тодорхой яам, газар, агентлагийн төсвийн талаар сонсгол зохион байгуулж, энэ үеэр олон нийтийн нотлох мэдүүлгийг сонсох.
- Аудитын шалгалтад олон нийтийн оролцоог хангах албан ёсны механизм бүрдүүлэх.

3. Төсвийн хяналтыг сайжруулах чиглэлээр:

- Төлөвлөснөөс илүү төсвийн орлого шилжүүлэн ашиглах, нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль тогтоох байгууллагаар батлуулдаг болох.
- Хууль тогтоох байгууллагын зүгээс аудитын тайланг хэлэлцэх олон нийтийн уулзалтууд зохион байгуулах зэрэг болно.

ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ - 2015



Дүнг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.

СУДАЛГААНД ХАМРУУЛСАН ТӨСВИЙН 8 БАРИМТ БИЧИГ


- Төсвийн хүрээний мэдэгдэл
- Гүйцэтгэх засаглалын төсвийн санал
- Иргэдэд зориулсан төсөв
- Жилийн явцын тайлангууд
- Хагас жилийн тойм
- Батлагдсан төсөв
- Жилийн эцсийн тайлан
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦЫН ЦАХИМ ЦАГЛАБАР

Улсын болон орон нутгийн төсөв боловсруулах, хэлэлцэх, батлах, тайлагнах зэрэг нь жилийн турш үргэлжилдэг үйл явц юм. Иргэд, иргэний нийгэм энэхүү үйл явцын цаг хугацааны талаар мэдээлэлтэй байх нь төсвийн үйл явцад оролцох, дуу хоолойгоо цаг тухай бүрт нь бодлого боловсруулагчдад хүргэхэд чухал ач холбогдолтой. Иймд бид төсвийн болон мэдээллийн ил тод байдлын холбогдох хууль эрх зүйн баримт бичигт үндэслэн улс, орон нутгийн төсвийн үйл явцын цахим цаглабарыг боловсрууллаа. Энэхүү цахим цаглабараас Засгийн газар, аймаг, нийслэлээс эхлээд төсвийн байгууллагуудын захирагчдын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хуваарийг мэдэх боломжтой. Тухайлбал, Засгийн газраас Монгол Улсын дараа оны төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх, УИХ-аас улсын төсвийг батлах, төсвийн захирагчдаас төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтаа төлөвлөх, гүйцэтгэлээ тайлагнах болон Засгийн газрын гадаад зээл, тусламж, гадаад, дотоод өрийн мэдээлэл зэрэг төсвийн мэдээллийг нийтэд ил тод болгох ёстой хуулийн хугацааг харж болно. Цаглабарыг [www.forum.mn](http://www.forum.mn) болон [www.forum.mn/tsaglabar/index.php](http://www.forum.mn/tsaglabar/index.php) сайтаас үзнэ үү.

“ИРГЭД ТӨСВӨӨ ХЯНАНА” СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсад төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад нөлөөлөх чиглэлээр ажилладаг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний үйл ажиллагааг ННФ дэмжиж ажилладаг билээ. Тус сүлжээний энэ онд хийсэн гол ажлуудаас дурдвал, төсвийн мэдээллийн [www.tusuv.mn](http://www.tusuv.mn) цахим хуудсыг шинэчлэн ажиллуулж, сүлжээний гишүүн байгууллагуудын ажиглалт, мониторингийн явцад цуглуулсан төсвийн холбогдолтой мэдээллийг байршуулан олон нийтэд тогтмол хүргэж ирлээ. Сүлжээнээс мөн 2016 оны нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж, батлах Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан ба баримт бичгийн ил тод, нээлттэй байдалд мониторинг хийх ажлыг эхлүүлээд байгаа ба дүнг 2016 оны эхээр танилцуулах юм.



Төсвийн цахим цаглабарт ойрын үед болох улсын болон орон нутгийн төсвийн үйл явцыг мэдээлэхээс гадна төсвийн үйл явцын талаар сануулга мэдээлэл авах хүсэлтэй хэрэглэгч цахим шуудангийн хаягаа бүртгүүлснээр ирэх 7 хоногт нь болох үйл явцын мэдээллийг цахим шуудангаараа хүлээн авах боломж бүрдэж байгаагаараа энэхүү цаглабар нь онцлогтой юм.

[www.tusuv.mn](http://www.tusuv.mn) цахим хуудас нь Монгол Улсын төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийг нийтэд хүргэдэг. Энэхүү цахим хуудсыг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд хөтөлдөг.



## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА БИЗНЕСИЙН ОРЧИН

Аль ч улсын эдийн засгийн хөгжилд төр засгийн зүгээс баримталж байгаа төсвийн оновчтой бодлого, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх нь чухал нөлөөтэй байдаг. ННФ арав гаруй жилийн туршид улсын төсвийн бодлого, төлөвлөлтийг бусад байгууллага, судлаачидтай хамтран судалж бие даасан, хөндлөнгийн судалгааны дүнг бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэж ирлээ. Үүнд, улсын төсвийн төлөвлөлт, өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг тодорхойлох судалгааг жил бүр хийж байна.

### УЛСЫН ТӨСВИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байгаа нь сүүлийн жилүүдийн төсвийн үйл явцаас тод томруун харагдах боллоо. Тухайлбал, төсөв их хэмжээний алдагдалтай батлагдаж, Засгийн газар уг батлагдсан түвшнээс илүү их алдагдал үүсгэн, жил бүр төсөвт тодотгол хийж байгаа нь төсвийн сахилга батыг улам бүр сулруулж байна. Төсвийн алдагдлаа нөхөх зорилгоор Засгийн газар жил дараалан дотоодын болон гадаадын бонд гаргах болсон. Улмаар төсвийн хуримтлагдсан алдагдлын хэмжээ нэмэгдэж түүнийг цаашид санхүүжүүлэхэд түвэгтэй нөхцөл үүсэж, эх үүсвэр улам бүр өндөр зардалтай болсоор байна.

Улсын төсөв боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шатуудаас Засгийн газар боловсруулж УИХ-д өргөн барьдаг дараа оны төсвийн саналд урьдчилан шинжилгээ хийж, батлагдахаас нь өмнө нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь төсвийн төлөвлөлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Иймд ННФ Монгол Улсын 2016 оны Нэгдсэн төсвийн төсөлд тойм судалгаа хийв.

### ТОЙМ СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮГНЭЛТ

- 2016 оны төсвийг 0.9 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар тооцжээ. Гэтэл Засгийн газрын гадаад зээл, баталгаат гадаад өрийн томоохон эргэн төлөлт 2017, 2018, 2022 онуудад хийгдэхээр байгаа.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна. Үүний тулд Засгийн газар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд өндөр ач холбогдолтой төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөх, УИХ-аас тэдгээрийн санхүүжилтийн дүнг бууруулахгүй батлах нь чухал.
- 2010-2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болсон төсөл арга хэмжээний санхүүжилтийг УИХ 20-40 хувиар бууруулж баталснаас он дамжсан дуусдаггүй барилгын тоо нэмэгдсэн. 2016 онд урьд оноос шилжин баригдаж буй барилгыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх зорилт тавьсан нь сайшаалтай боловч төсвийн хүндрэлтэй үед нэн тэргүүнд шаардлагагүй төслүүдийг шинээр хэрэгжүүлэхээр оруулсан.
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай (Тойм судалгааг бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

### ТӨСВИЙН АСУУДЛААРХ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Бид улсын төсвийн төсөлд хийсэн тойм судалгааны дүнг бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд болон иргэний нийгмийнхний хүрээнд танилцуулах уулзалт хэлэлцүүлэг жил бүр зохион байгуулж ирлээ. 2016 оны улсын төсвийн төлөвлөлтийн асуудлаар 2015 оны 11 дүгээр сард “Монгол Улсын 2016 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт”, “Монгол Улсын 2016 оны төсвийн тэнцэл, өрийн удирдлага” сэдэвт цуврал хэлэлцүүлэг зохион байгуулагдав.

Хэлэлцүүлгийн үеэр Сангийн Яамнаас 2016 оны улсын төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, өрийн удирдлага, ННФ-ын санаачилгаар судлаачид төсвийн төлөвлөлтөд хөндлөнгийн, хараат бус тойм дүгнэлт хийснээ тус тус танилцууллаа.

2016 оны төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт, хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл, илтгэлүүд, улсын төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлын талаарх мэдээлэл зэргийг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд хүргэлээ.



Монгол Улсын 2016 оны төсвийн төлөвлөлтийн асуудлаарх хэлэлцүүлэг, 2015 оны 11 дүгээр сар. Дээд эгнээний зүүн гар талаас: ННФ-ын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам, ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбат, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ё.Амарбат, ННФ-ын УЗ-ийн дарга Г.Уранцоож, уулзалтад оролцогчид

БИЗНЕСИЙН ОРЧИН

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийнхаа дүнг 9 дүгээр сард дэлхий даяар танилцуулав. Өрсөлдөх чадварын индексээр дэлхийн улс орнуудыг 12 тулгуур хүчин зүйл дээр үндэслэн эрэмбэлдэг энэхүү тайланд Монгол Улс 11 дэх жилдээ оролцож байна.

ННФ нь ДЭЗФ-ын түншээр 11 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд энэхүү тайлан дахь Монгол Улсын зэрэглэлийг 10 дугаар сард танилцууллаа. Энэ жилийн судалгааны дүнгээс харахад Монгол Улсын өрсөлдөх чадварт ахиц гарсангүй. Манай улс авбал зохих нийт 7 онооноос 3.8 авч судалгаанд хамрагдсан 140 орноос 104 дүгээрт эрэмбэлэгдлээ. Судалгаанд хамрагдаж эхэлснээс хойших 11 жилийн хугацаанд манай улс 3.2-3.9 оноо авч байгаа нь өрсөлдөх чадварын хувьд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.

Өрсөлдөх чадварын судалгааны дүнг олон нийтэд өргөн хүрээнд танилцуулж ажилласнаар төр засгийн зүгээс уг судалгааны дүнд анхаарал хандуулдаг болоод байна. Тухайлбал, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд өрсөлдөх чадварын үзүүлэлт орсон нь судалгааны ач холбогдлыг улам нэмэгдүүлж, өрсөлдөх чадварын судалгааны дүнг төр засаг бодлого шийдвэртээ ашиглаж байгааг харуулж байна. Уг үзэл баримтлалд өрсөлдөх чадварын үзүүлэлтээр одоо байгаа түвшинг урагшлуулж, дэлхийд өрсөлдөх чадвар сайтай эхний 70 орны нэг болох зорилт дэвшүүлжээ.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ОНОО, 2015-2016 ОН (12 ТУЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР)



Эх сурвалж: ДЭЗФ-ын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд

Өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур үзүүлэлтээс макро эдийн засгийн тогтвортой байдал, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, инноваци зэрэг 5 үзүүлэлтээр авбал зохих онооны 50 хувьд ч хүрч чадаагүй байна. Харин 10 гаруй үзүүлэлтээр эхний 50 байрт багтсан нь тэмдэглүүштэй явдал болов. Эдгээрээс дурдвал, цалин хөлс тогтоох уян хатан байдлаараа 9-д, хөрөнгө оруулагчийн хамгаалалт, татварын нийт хувь хэмжээ, бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах журмын тоо, цалин хөлс ба бүтээмж, ДНБ-д эзлэх үндэсний хуримтлалын хувь хэмжээ зэргээрээ 14-44-т эрэмбэлэгджээ (Судалгааны дүнгийн дэлгэрэнгүй танилцуулгыг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.).

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ

ТӨРИЙН ӨМЧИТ ЭРЧИМ ХҮЧНИЙ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ

Монгол Улсын төрийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалыг сайжруулахад нөлөөлөх ажлын хүрээнд манай улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болох эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын засаглалыг үнэлэх судалгааг ННФ санаачлан Эрчим Хүчний Яам (ЭХЯ)-тай хамтран хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаа нь компанийн засаглалын түвшинг тодорхойлох олон улсын аргачлалын дагуу хийгдсэн болно. Манай улсад компанийн засаглалын зохицуулалт сайжирч, зарим ахиц дэвшил гарч байгаа ч судалгаанд хамрагдсан эрчим хүчний 13 компанийн хувьд засаглалын чанар нь 36 хувьтай гарчээ. Энэ нь компанийн засаглалын талаар гарсан хуулийн заалтууд болон энэ талаар олон улсын байгууллагаас гаргасан нийтлэг зарчим хэрэгжихгүй байгааг харуулж байна. Ялангуяа мэдээллийн ил тод, нээлттэй байдал, чухал хэлцэл болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хамгийн сул үнэлгээ авав.



Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээний дүнг танилцуулах уулзалт, 2015 оны 10 дугаар сар. Дээд эгнээний зүүн гар талаас: ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт нар, уулзалтад оролцсон салбарын төлөөлөгчид, үнэлгээг хийж гүйцэтгэсэн судлаач Д.Байлхүү

Судалгаанаас хувьцаа эзэмшигч болон компанийн хоорондын харилцаа, төрийн төлөөлөл, түүнийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан Зөвлөмж гаргаж, компани тус бүрт хүргүүлээ. Мөн энэхүү үнэлгээнд үндэслэн Төрийн өмчийн тухай хуулийн төсөлд тодорхой санал өглөө. 2015 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан засаглалын үнэлгээний дүнг танилцуулах уулзалтад оролцсон ЭХЯ, Төрийн өмчийн хороо, үнэлгээнд хамрагдсан компаниудын удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл энэхүү судалгаанаас гарсан Зөвлөмжийг цаг үеэ олсон, чухал ач холбогдолтой гэж үнэлэв.

Цаашид ННФ төрийн өмчит эрчим хүчний томоохон компаниудын төсөв, санхүүгийн ил тод байдалд мониторинг хийх, энэхүү үнэлгээгээр гарсан Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



#### ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ

Төрийн өмчит уул уурхайн компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж, 2014 онд төрийн өмчийн уул уурхайн 9 компанийг хамран хийсэн засаглалын үнэлгээний нэгдсэн тайланг Англи хэлнээ хөрвүүлж хэвлэлээ. Түүнчлэн, дээрх үнэлгээний Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн өмчит компаниудад дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах нь” сэдэвт төрийн өмчит хувьцаат компаниудад зориулсан гарын авлага боловсруулж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуулийн дагуу, үр дүнтэй зохион байгуулах нь зөвхөн компанийн засаглалыг сайжруулан эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, нийтийн баялгийн ашиглалтыг сайжруулах төдийгүй хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх ач холбогдолтой билээ.



## БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

- ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ
- БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО
- ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

## ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

Уг хөтөлбөрийн 2015 оны зорилго нь боловсролын салбарт идэвхтэй ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, харилцан дэмжлэгийг тогтворжуулах, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хянахад бие даан болон хамтран оролцох чадавхыг бэхжүүлэх явдал байлаа.

Хөтөлбөрийн 2015 оны үйл ажиллагааны томоохон хэсэг нь Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээний чадавхыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдлээ. 2014 оны сүүлээр ННФ-ын санаачилгаар анхны уулзалтаа хийж, стратегийн төлөвлөгөөгөө боловсруулснаар ажлаа эхэлсэн уг Сүлжээнд боловсролын судалгаа, шинжилгээний ТББ, багш сургуулийн хөгжлийг дэмжин ажилладаг ТББ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудтай ажилладаг сайн дурынхны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын ТББ, хүний эрхийн байгууллага, боловсролын үндэсний эвсэл зэрэг 14 ТББ багтаж байна. 2015 онд сүлжээний гишүүд сар бүр уулзаж, мэдээлэл солилцох, санал бодлоо нэгтгэн бодлогын зөвлөмж гаргах, тодорхой асуудлаар хэлэлцүүлэг хийх, туршлага судлах, сургалт хийх зэргээр үр өгөөжтэй хамтран суралцаж ирлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, “Бүх нийт боловсролын төлөө” үндэсний эвсэл, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ, Бодлогод залуусын хяналт ТББ нь сүлжээний уулзалтыг төлөвлөн зохион байгуулж илтгэл тавих, мэдээлэл хийх зэргээр идэвхтэй ажиллав. 2015 оны 3 дугаар сараас ННФ-аас Сүлжээний гишүүдэд бодлогын судалгаа, бодлогын хэрэгжилтийн мониторингийн арга зүй танилцуулах цуврал сургалт зохион байгуулж сүлжээний байгууллагууд хүний эрх, сурч боловсрох эрх, тэгш хамруулан

Эрх зүйн орчин ойлгомжгүй, хэт ерөнхий байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтыг дэмжих зорилготой нэмэлт арга хэмжээ, санхүүжилтийн боломжийг зөвхөн тусгай сургуульд зориулсан нэмэлт дэмжлэг гэж ойлгох явдал түгээмэл байна.

саажилттай хүүхдийн боловсролын нөхцөл байдалд, Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн сургалтын чанарт, “Тэгш эрх, хөгжил үндэсний төв” ТББ хичээлийн бус цагаар хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрүүд харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль дээр хэрхэн хэрэгжиж байгаад тус тус мониторинг хийлээ.

Тархины саажилттай хүүхэд оюуны хүнд хэлбэрийн бэрхшээлтэй тул тусгай сургуульд сурах ёстой, асаргаа их шаардах тул сурах боломжгүй гэж үзэх багш, эцэг эхийн сөрөг хандлага; сургуулийн дотор болон ирж, очих дэд бүтцийн хүртээмжгүй байдал, сургалтын үед оролцох боломжгүй дасгал, даалгавар таарах зэрэг олон саадыг даван туулдаг байна. Гэтэл босго, довжоо зэрэг тогторыг арилгаж, хичээл дээр туслах хэрэгсэл ашиглах, даалгаврыг бичгээр биш амаар гүйцэтгэхийг зөвшөөрөх, сургуулийн унаагаар үйлчлэх зэрэг энгийн бөгөөд түгээмэл зохицуулалт хийхэд л оюун ухааны өндөр чадамжтай эдгээр хүүхэд амжилттай суралцаж дээд боловсрол эзэмшин, мэргэжлийн ажил эрхэлж байгаа жишээ олон байдаг байна.

“Гэгээ мандал төв” ТББ-ын мониторингийн дүнгээс

Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн хичээлээс гадуурх “Авьяас” хөтөлбөр амжилттай хэрэгжин дуу, хөгжмийн дугуйланд суралцдаг хүүхдүүд уралдаан, наадамд идэвхтэй оролцож байна. Спортын дугуйлан сайн ажиллахгүй байгаа ч биеийн тамирын дасгал, хөдөлгөөнийг цагийн хуваарьтаа оруулан хэрэгжүүлж байв. Харин “Ном” хөтөлбөрийг тус сургууль дээр хэрэгжүүлэхэд Брайл үсгийн болон сонсдог хүүхдийн номоос гадна харааны бэрхшээлийг харгалзсан бүтээлч сэтгэлгээний арга зүй боловсруулах шаардлагатай байгаа ажээ. Ер нь харааны бэрхшээлтэй хүүхдүүд бие даан зорчиж үйлчилгээнд хүрч очих боломж муу тул хичээлийн бус цагийн нийгэм, соёлын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тус сургуульд нэмэлт дэмжлэг, анхаарал шаардлагатай нь харагдлаа.

“Тэгш эрх, хөгжил үндэсний төв” ТББ-ын судалгааны дүнгээс

Хуульд ердийн ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ)-ийг тэгш хамруулан сургах бодлого баримтлах тухай тодорхой заасан ч хэрэгжилтийг дэмжсэн механизм, зохицуулалтууд хийгдээгүй байна. Тухайлбал, ХБХ-ийг боловсролд тэгш хамруулах нь төрийн үүрэг мөн, тиймээс сургуулийн захирал тэднийг сургах нөхцөл, бололцоог бүрдүүлэх асуудлыг хариуцах үүрэгтэй ч “нөхцөл, бололцоо”-г нарийвчилж тайлбарлаагүй, шалгуур үзүүлэлт юм уу батлагдсан стандарттай холбоогүй учраас хэрэгжилтийг хангах, хянах боломжгүй. ХБХ гэж хэнийг хэлэх талаар нэр томъёоны тодорхойлолт, аргачлал байдаггүй тул сургуулиуд эдгээр хүүхдийн тоо мэдээг гаргахдаа, мөн сурах нөхцөл бололцоог хангах асуудалд үзэмжээрээ ханддаг ажээ.

“Түгээмэл хөгжил төв” ТББ-ын мониторингийн дүнгээс

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд анх 1962 онд орос хэлнээс орчуулсан сургалтын хөтөлбөрийг багш нарын хүчээр шинэчлэн хэрэглэсээр байна. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эзэмшиж байгаа боловсролыг Монгол Улсын ерөнхий боловсролын стандартад нийцүүлэн сайжруулах, тэдэнтэй ажиллах багш шинээр бэлтгэх, ажиллаж байгаа багш нарыг арга зүйн дэмжлэгээр хангах, сургалтын хэрэглэгдэхүүн болон сурах бичгийн хангамжийг сайжруулах шаардлагатай байгааг эцэг эхчүүд онцолж байв.

Сонсголын бэрхшээлтэй эцэг, эхчүүдийн холбооны мониторингийн дүнгээс

### ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ЗАРЧИМ

Тэгш хамруулан сургах боловсролын зарчим анх 1994 онд Испани Улсын Саламанка хотод хуралдсан Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх дэлхийн бага хурлаар хэлэлцэгдэж, хүлээн зөвшөөрөгджээ. Саламанкагийн тунхаг нэрээр танил болсон энэхүү зарчим нь хүүхэд төвтэй арга зүйгээр сургадаг ердийн сургуульд бүх хүүхэд сурах боломж бий болгохын тулд ялгаатай хэрэгцээнд нийцсэн боловсролын тогтолцоотой болохын төлөө анхааран ажиллахыг дэлхийн улс орнуудын төр засагт уриалжээ.

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох арга механизм нь тэгш хамруулах боловсролын бодлого мөн болохыг 2006 оны НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц баталгаажуулсан билээ. Уг Конвенцийн 24 дүгээр зүйлд улс орнуудын төр засаг нь бүх шатны боловсролын үйлчилгээг тэгш хамруулах зарчмаар зохион байгуулах замаар тэгш хүртээмжийг бий болгохын зэрэгцээ боломжит дэмжлэг, ганцаарчилсан нэмэлт үйлчилгээг хангаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах ёстой гэжээ.

Эх сурвалж: Боловсролын төлөө дэлхий нийтийн хөдөлгөөн ТББ. “Тэгш эрх, тэгш боломж” ном. [http://www.campaignforeducation.org/docs/reports/Equal%20Right,%20Equal%20Opportunity\\_WEB.pdf](http://www.campaignforeducation.org/docs/reports/Equal%20Right,%20Equal%20Opportunity_WEB.pdf)



Харин “Түгээмэл хөгжил төв” ТББ Боловсролын тухай багц хуульд багтсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотой зүйл заалтуудыг харьцуулан судлав. 2015 оны 12 дугаар сард ННФ-аас Сүлжээний гишүүдтэй хамтран “Тэгш хамруулах боловсрол” форум зохион байгууллаа. Форумд тавигдсан 11 илтгэл нь боловсрол ба хүний эрх, хөгжлийн бэрхшээлийн ангилал, хэлгүйн соёл ба хос хэлний зарчим зэрэг концепци, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төв ажиллуулж буй сургуулийн туршлага, Япон Улсын Осака мужийн сургуулиудын туршлага, Улаанбаатар хотын хоёр тусгай сургуулийн санал санаачилга, мөн Сүлжээний гишүүн байгууллагуудын мониторингийн дүн зэрэг сэдвийг хөндөв.

Зүүн гар талд “Тэгш хамруулах боловсрол” форумын үйл ажиллагааны зургууд.

Дээрээс: Форумд оролцогчид, Түгээмэл Төв ТББ-ын ажилтан Ч. Ундрахбаяр олон нийтийн телевизэд Форумын үйл явцын талаар ярилцлага өгч байгаа нь, Форумд оролцогчдод судалгааны тайлан, гарын авлага материалууд тарааж байгаа нь.

2015 оны 12 дугаар сар.  
Гэрэл зургийг Т. Амарзаяа

Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргахыг зориогүй, харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, багш, эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн уулзаж ярилцах газар болох зорилго тавьсан уг Форумд 100 гаруй хүн оролцов. Сүлжээнээс мөн тэгш хамруулах боловсролын үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Тэгш хамруулах сургах боловсролын нэр томъёоны тайлбар толь” нэртэй ном боловсруулж, хэвлэхэд бэлэн болгоод байна. Олон улсын болон дотоодын судалгааны эх сурвалж, НҮБ, олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмж, бусад орны тэргүүн туршлага зэрэг арвин их мэдээллийг шүүж, нэгтгэн боловсруулсан энэ номд тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, түгээмэл загвар, туслах хэрэглэгдэхүүн зэрэг нэр томъёог тайлбарлан, амжилттай хэрэглэж буй жишээ, туршлагыг ч багтаажээ. Энэ ном тэгш хамруулах боловсрол, сурч боловсрох тэгш эрх зэргийг бүрэн дүүрэн дэлгэн тайлбарлаж чадахгүй ч нэгдсэн ойлголт руу хөтлөх нэг алхам болох юм.



Баруун гар талд “Тэгш хамруулах боловсрол” форумын зарим илтгэгчид  
Дээд эгнээнээс:

Боловсролын хамтын ажиллагааны Нийгэмлэг ТББ-ын ажилтан О.Саранцэцэг, Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуулийн захирал Б.Батсайхан, Гэгээ мандал ТББ-ын тэргүүн Д.Од, Сонсголгүйн боловсрол ТББ-ын захирал А.Баасанжав, Тэгш эрх, хөгжил үндэсний төв ТББ-ын ажилтан Л.Санчир нар  
2015 оны 12 дугаар сар. Гэрэл зургийг Т. Амарзаяа

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО

Дэлхий нийтээр улам өргөжин төлөвшиж байгаа Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоо манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үйлчилгээ хэлбэрээр нэвтэрч эхлээд байна. 2013 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны манлайлал дор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний Комисс байгуулагдахаас өмнө Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн нийгмийн цогц үйлчилгээний тогтолцоо байгаагүй. Шинэ тутам энэхүү тогтолцоог хөгжүүлэх стратегийн төлөвлөлт хийх, орон нутагт салбаруудаа бий болгон дотоод дүрэм, журам, ашиглах аргачлал, хэрэглэгдэхүүнээ бий болгох нөр их ажлыг Комисс цөөн орон тооны албан хаагчдынхаа хүчээр гүйцэтгэж байна.

ННФ энэ үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэн 2014 оноос хамтран ажиллаж байгаа түнш байгууллагын хувьд 2015 онд Комиссын гишүүдэд шаардлагатай техник, арга зүйн мэдээлэл дамжуулах, хувилбарт аргачлалуудыг танилцуулах, эх сурвалж материалаар хангах зэргээр өдөр тутмын ажлыг нь дэмжихийн зэрэгцээ баримт бичгийн боловсруулалтад туслан хамтран ажиллалаа. 2015 оны 10 дугаар сард АНУ-аас бага насны хүүхдийн хөгжлийн мэргэжилтэн урьж авчран, 5 хоногийн эрчимтэй сургалт семинараар төв Комиссын 5 гишүүн, дүүргийн салбар комиссын гишүүдэд шинээр байгуулж буй тогтолцоо, түүний зорилго, бүтэц бүрдлийг танилцуулж, дунд хугацааны Стратегийн төлөвлөгөө боловсруулахад нь удирдамж заавар өгч ажиллав. Стратегийг эцэслэн боловсруулж, батлуулах, цаашилбал дүүрэг, аймгийн салбар комисст хүргэн танилцуулах ажлыг Комисс 2016 онд хийх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцооны талаар дотоодын мэдлэг, туршлага байхгүй учраас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл” номыг ННФ-аас орчуулан хэвлэж, нийслэл болон орон нутгийн холбогдох хүмүүст хүргээд байна. Номоо танилцуулах нээлтийн арга хэмжээн дээр гарсан саналын дагуу номын агуулгаар сургалтын модуль боловсруулж Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комисстой хамтран нийгмийн салбарын мэргэжилтнүүдэд сургалт хийж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд шинэ тогтолцооны нэг оролцогч, ашиг шимийг нь хүртэгч тул анхнаасаа оролцоотой байх нь чухал гэж үзсэн ба бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн явцыг үнэлэх аргачлал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй зэрэг асуудлаар хэд хэдэн ТББ-ын тодорхой үйл ажиллагааг дэмжин ажиллав. Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ хүүхдийн хөгжлийн үнэлгээний чиглэлээр дотоод чадавхаа хөгжүүлэн төрийн болон төрийн бус байгууллагуудад мэдээлэл, зөвлөгөө өгч энэ салбарт мэргэшсэн ТББ болоход нь дэмжлэг үзүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо орон нутгийн салбаруудаа хамруулан дунд хугацааны Стратегия боловсруулах, үүнд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чадавхыг дотроо хөгжүүлэх асуудлаар агуулгын болон санхүүгийн туслалцаа авч ажиллаж байна. Монголын Дауны холбооноос оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад ашиглаж болох арга зүйн номыг англи хэлнээс орчуулсан ба хэвлэх зардлыг ННФ хангаж өглөө.

## ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Нээлттэй Нийгэм Форум нь өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудалд үндэсний болон орон нутгийн бодлого, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулж, улмаар хүн амын хөгжил, залуучуудын бодлого, хөтөлбөрийн нэг хэсэг болгож дэвшүүлэх зорилготой энэхүү хөтөлбөрийг хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. Хүний амь нас, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөрөг нөлөөтэй хүчирхийлэл, түрэмгийлэл нь дэлхийн хэмжээнд залуу хүмүүсийн нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болоод байгааг олон улсын байгууллагууд анхааруулж, улс орнууд өөр өөрийн соёл, хүн амын бүтцийн онцлогт нийцсэн үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж байна. Залуучуудын дундах хүчирхийллийг нэгдсэн бодлого, төлөвлөгөөт үйл ажиллагаагаар урьдчилан сэргийлэх нь хувь хүний төлөвшил, хүний хөгжилд дэм болоод зогсохгүй нийгэм, эдийн засгийн дэвшилд эерэг нөлөөтэй болох нь олон судалгаа, тооцоогоор батлагдаад байгаа ба нийт хүн амын 40 орчим хувь нь 35 нас хүрээгүй, “залуучуудын орон” гэж зүй ёсоор нэрлэгддэг манай улсад энэ бодлого үр өгөөжтэй байх нь дамжиггүй.

2015 онд ННФ нь хэлэлцүүлэг, сургалтаар уг асуудалд мэргэжлийн хүмүүсийн анхаарлыг татан, мэргэжил, арга зүйн хэрэгцээг өдөөн дэмжих, түүнд нийцсэн мэдлэг, мэдээлэл бий болгох нийлүүлэлтийн тал буюу судлаачдын сонирхол, чадавхыг нэмэгдүүлэн ажиллав. Үүний үр дүнд томоохон судалгаанд хавсарга маягаар дурдагдаад өнгөрдөг байсан залуучуудын дундах хүчирхийллийг дагнан судалсан материал, энэ чиглэлд ажиллах сонирхолтой судлаачдын тоо нэмэгдэж, улмаар өсвөр насны хүүхэд, залуучуудтай ажилладаг хороо, дүүргийн мэргэжлийн хүмүүсийн хувьд ажилдаа авч ашиглаж болох мэдээлэл, арга зүй бий болж байна.

2014 онд иргэний нийгмийн 4 байгууллагаас хотын захын хороо, оюутны байранд хийсэн залуучуудын дундах хүчирхийллийн судалгаа, ННФ-ын боловсруулсан олон улсын судалгаа, зөвлөмжийн тойм зэргийг ашиглан

2015 онд хороо, дүүргийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, их дээд сургуулийн судлаач, төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг хамруулсан цуврал хэлэлцүүлэг, семинар хийлээ. Оролцогчид дээрх материалыг сум, хороо бүрт ажиллаж байгаа Хүүхэд хамгааллын хамтарсан багуудад нэн шаардлагатай байгаа өсвөр насны хүүхэдтэй ажиллах арга зүй болж чадна хэмээн үнэлсэнд урамшин, нийгмийн эрүүл мэндийн салбарын судлаач багш нарын дэмжлэгтэй боловсруулсан кейсийн судалгааны арга зүйг хороо, сургуулийн нийгмийн ажилтанд зориулсан аргачлал болгон боловсруулж байна.

**6-11-р ангийн ангийн сурагчдын 98,6 хувь нь сургуулийн орчинд ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртдөг ба үйлдэж буй гол субъект нь юуны өмнө үе тэнгийнхэн нь байдаг.**

(БСШУЯ, 2007, “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам” тайлан, 14 болон 68-р тал.)

Мөн оролцогчидтой зөвлөлдсөний үндсэн дээр залуучуудын дундах хүчирхийллийг таньж баримтжуулахад ашиглах хяналтын хуудас, өдөөгч хүчин зүйлсийг нь шинжлэн тогтоох арга зүй, тодорхой нөхцөлд нийцтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг багтаасан цогц аргачлал боловсруулж сум, хорооны Хүүхэд хамгааллын багуудын ажилд нэвтрүүлэх зорилт тавьж ажиллах хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо.

Өөрийн гэсэн бодлого, үйл ажиллагааны туршлага хомс энэ чиглэлд олон байгууллагыг татан ажиллуулах зорилгоор ННФ бусад ТТБ-аар гэрээт болон тэтгэлэгт ажил гүйцэтгүүлэв. Иргэний нийгмийн байгууллага, ялангуяа залуучуудын байгууллагууд энэ сэдвээр ажиллах сонирхолтой байгаа нь ажиглагдсан ба Бодлогод залуусын хяналт, Иргэний боловсрол төв маш идэвхтэй хамтран ажиллаж, богино хугацаанд арвин их мэдээлэл цуглуулж хэд хэдэн арга зүйг туршаад байна. Ахлах ангийн сурагчид, хорооны залуучуудын дунд хүчирхийллийн кейсийг илрүүлэх, хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээлэл хүргэхэд кино хэлэлцүүлэг, “Дотно яриа” лекц-хэлэлцүүлгийн загвар үр өгөөжтэй байжээ. Оролцогч залуучуудын амьдралд нийтлэг тохиолддог үйл явдалд тулгуурласан богино кино, асуудал хөндсөн лекц нь залуучуудын дунд илэн далангүй, найрсаг уур амьсгал бүрдүүлэхэд дэм болж, хэлэлцүүлгийг идэвхжүүлэхэд тустай байв. Харин үе тэнгийн дарамт, хүчирхийллийн талаар мэдээлэл авах утас ажиллуулсан нь үр дүнд хүрээгүй болно. Дээрх хоёр байгууллага өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд гарсан хүчирхийллийн 400 орчим кейс цуглуулсан дүнг сургалт, судалгаандаа ашиглаж байна. Мөн амжилттай хэрэгжсэн загваруудын бэлтгэл, хэрэгжилт, үнэлгээг хамарсан удирдамж боловсруулж сургууль, хороо, дотуур байрны нийгмийн ажилтнуудад зориулсан илрүүлэлтийн хэрэглэгдэхүүн болгохоор бэлдэж байна.

Энэ салбарт залуучуудын өөрсдийн оролцоо нэн чухал тул бид залуучуудын төрийн бус байгууллага, баг, бүлгүүдтэй хамтран ажиллах арга хэлбэрүүдийг туршиж байна. Залуучуудын дуу хоолой болохын тулд залуучуудтай ойр ажиллаж танигдах, нөгөө талаас залуучуудын ашиг сонирхлыг хамгаалахын тулд мэдлэгтэй болоход нь туслах зорилгоор Бодлогод залуусын хяналт ТББ, түүний дэргэдэх залуу нийтлэлчдийн клубыг төслийн тэтгэлгээр дэмжин ажиллаж байна. Энэ тэтгэлгийн хүрээнд залуучууд хүчирхийлэл, түүнээс сэргийлэх талаар судалж олон нийтийн сүлжээг ашиглан бусадтай мэдээллээ хуваалцах, хүчирхийллээс ангид байх утга агуулгатай мэдээллийн кампанит ажил зохион байгуулах, бусад орны залуучуудын хөгжлийн бодлогод хүчирхийллээс сэргийлэх зорилтыг тусган хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж, бодлогын нөлөөллийн ажил төлөвлөөд ажиллаж байна.

2015 онд АШУИС-ийн НЭМС-тай эхлүүлсэн хамтын ажиллагаа үр дүнтэй түншлэл болон бэхжлээ.

## Хөгжингүй 40 орчим улсад хийсэн судалгаагаар хөвгүүдийн 42%, охидын 37% нь ямар нэг байдлаар дарамт, хүчирхийлэлд өртөж байжээ.


ДЭМБ, 2014, Залуучуудын дундах хүчирхийлэл. “Тоо баримт” цуврал, дугаар 356 (<http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>)

Нийгмийн ажилтны ангийн оюутнуудын судлах “Залуучуудын дундах хүчирхийлэл” сэдэвт 2 кредиттэй хичээлийн агуулга, хөтөлбөр, сурах бичиг боловсруулагдан 2017 оны өвлийн семестрээс зааж эхлэх бэлтгэл хангагдаж байна. Ирэх оноос залуучуудын дундах хүчирхийллийн асуудлаар ахлах курсийн оюутнуудыг хороон дээр дадлага хийлгэх, оюутны эрдэм шинжилгээний ажил хийлгэх бэлтгэл ажил эхэлсэн. НЭМС нь сургалтын хөтөлбөр, дадлагын болон эрдэм шинжилгээний ажлын загварыг нийгмийн ажилтан бэлтгэдэг бусад их дээд сургуульд тараан түгээх, цаашилбал нийгмийн ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх ажлыг ННФ-тай хамтран хэрэгжүүлэх юм.

### ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙН КЕЙС СУДАЛГАА /ЦУВРАЛ/



### ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ВИДЕО НЭВТРҮҮЛЭГ



Шинэ түнштэй болохын зэрэгцээ бид мөн шинэ асуудлаар хөтөлбөрийн хүрээг тэлж байна. Аливаа урьдчилан сэргийлэх бодлого нь стратегийн гурван түвшинтэй байдаг ба анхдагч сэргийлэлт нь нийт хүн амд чиглэсэн соён гэгээрүүлэх зорилготой байдаг бол хоёрдогч түвшний сэргийлэлт нь эрсдэлт бүлэгт хандсан хөтөлбөрүүд байдаг байна. ННФ, түнш байгууллагуудын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь анхдагч болон хоёрдогч түвшний урьдчилан сэргийлэлт болж байгаа бөгөөд нийт залуучуудыг хүчирхийллээс татгалзахад уриалах, хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх, гэрч болох магадлалтай хүүхэд залуусыг төлөвшүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаанд анхаарч байна. Харин давтан үйлдлээс сэргийлэх асуудалд төвлөрдөг гуравдагч сэргийлэлт нь манай зорилтот үйл ажиллагаа биш боловч гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг “Хөгжлийн хэлхээ” ТББ-ын санаачилгаар ял хойшилсон, хугацаанаас өмнө суллагдсан болон хорихоос өөр хэлбэрийн шийтгэл оноогдсон насанд хүрээгүй хүүхэд, тэдний гэр бүлд үзүүлж байгаа нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ, дэмжлэгийг баримтжуулах мониторингийн ажлыг дэмжин ажиллаж байна. Судалгаа дуусаагүй тул дүгнэлт хийх боломжгүй ч 30 орчим хүүхэдтэй холбоотой мэдээллээс үзэхэд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй сар бүрийн бүртгэл хяналтаас өөр тогтмолжсон ажил, үйлчилгээ тууштай илрэхгүй байна.

Хотын захын хороо, алслагдсан дүүрэг, оюутны дотуур байр гээд өөр өөр орчин нөхцөлд төвлөрсөн бие даасан 4 судалгааны дүнгээс харахад нэг анги, гудамжны бие биеэ сайн таньдаг залуучуудын дунд эрх мэдлийн тэмцлээс үүдэлтэй дарамт, сүрдүүлэг, ганцаардуулалт, нэр хоч өгөх, хэл амаар доромжлох явдал, мөн эдийн засгийн сэдэлтэй хүчирхийлэл нэлээд гардаг бол өөр анги, хороо, сургуулийн сайн танихгүй залуучуудын хооронд талцан зодолдох, мөнгө эд зүйл дээрэмдэх тохиолдлууд голдуу сагсан бөмбөгийн талбай дээр, эсвэл хүний нүднээс далд эл хуль газар гардаг байна. Ихэнхдээ эцэг эх мэдэхгүй өнгөрөх, мэдсэн ч өөрсдөө учраа олохыг зөвлөдөг бол хүүхэд шөнө унтахгүй, сургуульд явах дургүй болох, хичээлдээ муудах зэрэг дарамт стрессийн шинж тэмдэг илэрсэн үед ангийнхаа хүүхдүүдтэй ярьж зохицуулахыг оролддог ажээ. Ангийн багшид хэлж хурлаар ярилцаж зохицуулсан хэд хэдэн тохиолдол байгаа ч ангидаа нэр хүнд нь унах, багшийн ажлын үнэлгээ дордохоос эмээж нуун дарагдуулах явдал түгээмэл байв. Асуудал сургуулийн захиргааны түвшинд хүрсэн бол хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг сургуулиас хөөх, хасах шийдвэр голдуу гардаг байна. Давтан үйлдлээс сэргийлэх сэргээн засах үйлчилгээ буюу гуравдагч шатны урьдчилан сэргийлэлтийг хариуцах байгууллага, төсөв хөрөнгийн асуудлыг мөн шийдэх шаардлагатай байна.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2015 онд нийт 1,497,000 ам.долларын төсөвтэй ажиллалаа. Үүний \$1,323,000 нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүдээс; \$27,200 Азийн Сангаас; \$37,800 Азийн ЛОГИН сүлжээнээс; \$89,000 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгаас; \$11,800 Дэлхийн Нөөцийн Хүрээлэнгээс; \$8,200 бусад донор байгууллагаас тус тус санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

### НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Хүний эрх	16,487	45,266	61,753
Хууль эрх зүйн шинэтгэл	21,419	18,234	39,653
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх	19,011	41,924	60,935
Улс төрийн санхүүжилт	37,856	11,260	49,116
Төрийн ил тод хариуцлагатай байдал	-	-	-
- Мэдээллийн эрх чөлөө	8,905	5,112	14,017
- Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	104,049	24,128	128,177
- Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	22,086	13,182	35,268
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</b>			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	30,777	77,129	107,906
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	51,304	2,880	54,184
Эдийн засгийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин	-	5,201	5,201
Төрийн өмчит компаниудын засаглал	-	3,545	3,545
<b>БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР</b>			
Тэгш хамруулах боловсрол	36,219	38,183	74,402
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоо	4,585	12,680	17,265
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	34,256	5,334	39,590
<b>ЗАХИРГАА</b>	-	700,952	700,952
<b>НИЙТ ДҮН</b>	<b>386,954</b>	<b>1,005,010</b>	<b>1,391,964</b>

### ТЭТГЭЛГИЙН ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Нийт зардал
<b>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</b>			
Хүний эрх	12,966	3,521	16,487
Хууль эрх зүйн шинэтгэл	14,950	6,469	21,419
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх	17,596	1,415	19,011
Улс төрийн санхүүжилт	27,114	10,742	37,856
Төрийн ил тод хариуцлагатай байдал	-	-	-
- Мэдээллийн эрх чөлөө	8,905	-	8,905
- Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	104,049	-	104,049
- Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	14,897	7,189	22,086
<b>ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР</b>			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	30,777	-	30,777
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	51,304	-	51,304
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин	-	-	-
Төрийн өмчит компаниудын засаглал	-	-	-
<b>БОЛОВСРОЛ, НИЙГЭМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР</b>			
Тэгш хамруулах боловсрол	36,219	-	36,219
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоо	4,585	-	4,585
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	34,256	-	34,256
<b>НИЙТ ДҮН</b>	<b>357,618</b>	<b>29,336</b>	<b>386,954</b>



2015 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Хууль бидний амьдралд	ТББ \$507
2	Улаанбаатар	Хэрэглэгч сан	ТББ \$507
3	Улаанбаатар	Урагш дэвших холбоо	ТББ \$507
4	Улаанбаатар	Шинэ хамтрал	ТББ \$506
5	Улаанбаатар	Үнэн хатамж	ТББ \$506
6	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ \$506
7	Улаанбаатар	Хөгжлийн хэлхээ	ТББ \$506
8	Улаанбаатар	Миний нутаг Багануур	ТББ \$506
9	Улаанбаатар	Налайхын амьдрал сонин	ТББ \$506
10	Улаанбаатар	Эдийн засгийн клуб	ТББ \$506
11	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ \$2,292
12	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ \$7,179
13	Улаанбаатар	Гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн	ТББ \$4,247
14	Улаанбаатар	Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	ТББ \$3,877
15	Улаанбаатар	ХБИ-ийн байгууллагуудын үндэсний холбоо	ТББ \$4,833
16	Улаанбаатар	Хөвсгөл далай ээж	ТББ \$3,163
17	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ \$2,992
18	Улаанбаатар	Үндсэн уртраг	ТББ \$2,519
19	Улаанбаатар	Сэтгэлийн мэдрэмж	ТББ \$2,340
20	Улаанбаатар	Тэгш тус	ТББ \$1,315
21	Улаанбаатар	Хариуцлагатай уул уурхай	ТББ \$2,076
22	Улаанбаатар	Байгаль эхийн аврал сан	ТББ \$2,635
23	Улаанбаатар	Чингэлтэй дүүргийн ХБИ-ийн холбоо	ТББ \$2,596
24	Улаанбаатар	Байгаль эхийн аврал сан	ТББ \$2,612
25	Улаанбаатар	Иргэний шийдэл	ТББ \$4,541
26	Улаанбаатар	Шинэ хамтрал	ТББ \$2,027
27	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ \$2,741
28	Улаанбаатар	Гэгээ мандал	ТББ \$2,329
29	Улаанбаатар	Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо	ТББ \$3,116
30	Улаанбаатар	Монголын дауны холбоо	ТББ \$4,585
31	Улаанбаатар	Түгээмэл хөгжил төв	ТББ \$2,359

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
32	Улаанбаатар	ХБ-тэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо	ТББ \$23,561
33	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ \$9,673
34	Улаанбаатар	Хөгжлийн хэлхээ	ТББ \$2,670
35	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд	ТББ \$45,670
36	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ \$33,600
37	Улаанбаатар	Байгаль орчин эрүүл мэнд төв	ТББ \$17,600
38	Улаанбаатар	Глоб интернэшнл төв	ТББ \$7,443
39	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ \$19,671
40	Архангай аймаг	Мэдлэгийн сүлжээ	ТББ \$1,509
41	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн урианхай, тува дөрвөд иргэдийн нийгмийн холбоо	ТББ \$1,509
42	Баян-Өлгий аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ \$884
43	Баянхонгор аймаг	Амартайван итгэл	ТББ \$1,509
44	Баянхонгор аймаг	Хонгор нутгийн дуудлага	ТББ \$3,551
45	Булган аймаг	Булганы мэдээ	ТББ \$1,509
46	Булган аймаг	Хуульч эмэгтэйчүүдийн холбоо	ТББ \$891
47	Говь-Алтай аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$1,512
48	Говьсүмбэр аймаг	Хотол Чойр	ТББ \$1,408
49	Говьсүмбэр аймаг	Хөгжлийн түншлэл	ТББ \$1,307
50	Дархан уул аймаг	Худалдаа аж үйлдвэрийн танхим	ТББ \$1,509
51	Дархан уул аймаг	Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах төв	ТББ \$1,004
52	Дорноговь аймаг	Манлайлагч итгэл	ТББ \$1,407
53	Дорноговь аймаг	Цагаан соёмбо	ТББ \$1,731
54	Дорнод аймаг	Улс төрийн боловсролын академи	ТББ \$1,509
55	Дорнод аймаг	Улс төрийн боловсролын академи	ТББ \$3,013
56	Дорнод аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$1,782
57	Дундговь аймаг	Аймгийн иргэний нийгмийн сүлжээ	ТББ \$1,307
58	Дундговь аймаг	Аймгийн хөдөөгийн эмэгтэйчүүдийг дэмжих сан	ТББ \$1,408
59	Дундговь аймаг	Говийн хөгжил наран	ТББ \$2,242
60	Дундговь аймаг	Скаутын холбоо	ТББ \$1,839
61	Завхан аймаг	Сэтгэлийн долгион	ТББ \$1,408
62	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ \$1,307
63	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ \$3,671
64	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ \$1,007

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
65	Орхон аймаг	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ \$1,509
66	Орхон аймаг	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	ТББ \$1,004
67	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ \$1,307
68	Өвөрхангай аймаг	Орон нутгийн шинэ санаачилга	ТББ \$1,408
69	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ \$1,255
70	Өвөрхангай аймаг	Эх нутаг хөгжил төв	ТББ \$1,493
71	Өмнөговь аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$1,408
72	Өмнөговь аймаг	Баг сумдын үндэсний холбоо	ТББ \$1,307
73	Өмнөговь аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ \$1,411
74	Өмнөговь аймаг	Баг сумдын үндэсний холбоо	ТББ \$2,790
75	Өмнөговь аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$2,560
76	Сүхбаатар аймаг	Монголын үйлдвэр үйлчилгээ хоршоодын холбооны салбар	ТББ \$1,509
77	Сэлэнгэ аймаг	ЖДҮ, аж ахуйн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоо	ТББ \$1,513
78	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ итгэл ажил олгогч эздийн холбоо	ТББ \$976
79	Төв аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ \$1,509
80	Төв аймаг	Тэгш эрх, хөгжил үндэсний төв	ТББ \$2,114
81	Төв аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$2,632
82	Увс аймаг	Увс хөгжилд иргэдийн оролцоо төв	ТББ \$1,509
83	Увс аймаг	Гэргий ухаан	ТББ \$1,005
84	Ховд аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ \$1,513
85	Ховд аймаг	Хэвлэлийн хүрээлэн	ТББ \$1,407
86	Ховд аймаг	Ховдын толь	ТББ \$4,947
87	Ховд аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд	ТББ \$2,450
88	Ховд аймаг	Нийгмийн хариуцлага- Иргэдийн оролцоо	ТББ \$1,004
89	Хөвсгөл аймаг	Хөвсгөлийн хөгжил дэвшилд	ТББ \$1,408
90	Хөвсгөл аймаг	Улс төрийн боловсролын академи	ТББ \$1,307
91	Хөвсгөл аймаг	Хөвсгөлийн хөгжил дэвшилд	ТББ \$2,558
92	Хөвсгөл аймаг	Сүүн тахилт	ТББ \$1,001
93	Хэнтий аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ \$1,509
94	Хэнтий аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ \$1,842
95	Архангай аймаг	Хөгжимт драмын театр	Төрийн \$1,026
96	Дархан-Уул аймаг	Хөгжимт драмын театр	Төрийн \$1,026

Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
97	Дорноговь аймаг	Саран хөхөө чуулга	Төрийн \$1,026
98	Хөвсгөл аймаг	Хөгжимт драмын театр	Төрийн \$1,026
99	Төв аймаг	Монгол туургатан	Төрийн \$1,026
100	Улаанбаатар	Отгонтэнгэр дээд сургууль	Сургууль \$2,210
101	Улаанбаатар	Орхон дээд сургууль	Сургууль \$1,642
102	Улаанбаатар	МУИС-ийн Хууль зүйн сургууль	Сургууль \$543
103	Улаанбаатар	Шихихутуг дээд сургууль	Сургууль \$1,955
104	Улаанбаатар	АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль	Сургууль \$21,913
105	Улаанбаатар	Л.Төр-Од	Иргэн \$1,831
106	Улаанбаатар	Д.Сүхгэрэл	Иргэн \$2,042
107	Улаанбаатар	Т.Ганбаатар	Иргэн \$1,657
108	Улаанбаатар	Э.Энхтуяа	Иргэн \$1,604
109	Улаанбаатар	Ч.Раднаабазар	Иргэн \$1,604
110	Улаанбаатар	С.Саруул	Иргэн \$1,604
111	Улаанбаатар	Б.Өлзий-Эрдэнэ	Иргэн \$1,259
112	Улаанбаатар	Б.Долгор	Иргэн \$1,368
113	Улаанбаатар	М.Батбаатар	Иргэн \$1,255
114	Улаанбаатар	Д.Баасандорж	Иргэн \$396
115	Улаанбаатар	П.Эрдэнэчимэг	Иргэн \$217
116	Улаанбаатар	Г.Нармандах	Иргэн \$215
117	Улаанбаатар	Ч.Гангэрэл	Иргэн \$1,638
118	Улаанбаатар	С.Насанжаргал	Иргэн \$1,638
119	Улаанбаатар	Ц.Өнөрцэцэг	Иргэн \$2,803
120	Улаанбаатар	У.Золбаяр	Иргэн \$2,656
121	Улаанбаатар	Х.Эрдэнэбулган	Иргэн \$2,656
122	Улаанбаатар	Х.Насанжаргал	Иргэн \$1,479
123	Улаанбаатар	Д.Алтантуяа	Иргэн \$1,415

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

### Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

---

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХШУИС-ийн багш
Ц. Отгонбаатар	УЗ-ийн гишүүн
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал

### Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

---

П. Эрдэнэжаргал	<a href="mailto:jargal@forum.mn">jargal@forum.mn</a>
-----------------	--

### Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

---

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөрийн менежер	<a href="mailto:badmaa@forum.mn">badmaa@forum.mn</a>
Б. Баттуул	Засаглалын хөтөлбөрийн менежер (2015 оны 8 сар хүртэл ажилласан)	
А. Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер	<a href="mailto:gerelmaa@forum.mn">gerelmaa@forum.mn</a>
Д. Оюунбадам	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	<a href="mailto:oyunbadam@forum.mn">oyunbadam@forum.mn</a>
Б. Хишигсайхан	Засаглалын хөтөлбөрийн менежер	<a href="mailto:khishgee@forum.mn">khishgee@forum.mn</a>
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	<a href="mailto:enhee@forum.mn">enhee@forum.mn</a>
Д. Эрдэнэчимэг	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	<a href="mailto:dorjdari@forum.mn">dorjdari@forum.mn</a>
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	<a href="mailto:passistant@forum.mn">passistant@forum.mn</a>
У. Энхцэцэг	Хөтөлбөрийн туслах ажилтан	<a href="mailto:assistant@forum.mn">assistant@forum.mn</a>
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	<a href="mailto:fellowship@forum.mn">fellowship@forum.mn</a>
Д. Балжид	Мэдээллийн менежер	<a href="mailto:baljid@forum.mn">baljid@forum.mn</a>
Б. Мөнхгэрэл	Сэтгүүлч	<a href="mailto:munkhgerel@forum.mn">munkhgerel@forum.mn</a>
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	<a href="mailto:javkhlan@forum.mn">javkhlan@forum.mn</a>
Д. Аюуш	Оффис, тэтгэлгийн менежер	<a href="mailto:ayush@forum.mn">ayush@forum.mn</a>
Г. Одонмижид	Нягтлан бодогч	<a href="mailto:odnoo@forum.mn">odnoo@forum.mn</a>
Э. Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	<a href="mailto:sainaa@forum.mn">sainaa@forum.mn</a>
Д. Ганзул	Захирлын туслах	<a href="mailto:reception@forum.mn">reception@forum.mn</a>
Б. Баатар	Захиргааны ажилтан	<a href="mailto:baatar@forum.mn">baatar@forum.mn</a>
Г. Цэдэвхүү	Захиргааны ажилтан	<a href="mailto:tsedev@forum.mn">tsedev@forum.mn</a>
Н. Хүрэлболд	Захиргааны ажилтан	

---

Нийтлэг И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

---